



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



2018

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАНЫ ОРОЛЦОО - ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭС

Агуулга

5	Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
7	Говийн Оюу хөгжлийг дэмжих сан
9	Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн засаглал
10	Сангийн Удирдах зөвлөл
11	Харилцааны хороо
12	Говийн Оюу хөгжлийг дэмжих санд хүлээн авах төсөл, хөтөлбөрийн саналын чиглэл
12	Санхүүжилт олгох үндсэн чиглэл
14	Сангийн санхүүжилтийн хуваарилалтын стратеги 2018-2020
16	Санхүүжилт олгох үйл явц
17	Ирээдүй хойч үеийн төлөө сан
17	Говийн оюу-Бизнес боломж” бизнесийн бичил зээл
21	Ирээдүй хойч үеийнхэнд зориулсан хадгаламж
21	“Говийн Оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр
23	Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт
23	Сангийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрүүд
24	Сангаас 2018 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт
28	Сангийн 2018 оны онцлох үйл явдал
29	Удирдах зөвлөлөөс Сангийн 2018 оны санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт
30	Сангаас баталан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт
30	<i>Нийгмийн дэд бүтцийн чиглэлийн төслийн хэрэгжилт</i>
41	<i>Байгаль орчны менежментийн чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилт</i>
43	<i>Нийгмийн суурь үйлчилгээний чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилт</i>
56	<i>Усны менежментийн чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилт</i>
58	<i>Орон нутгийн бизнес хөгжил чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилт</i>

-
- 61 Квотын санхүүжилт, 2018 оны квотын санхүүжилтээр хэрэгжих төсөл хөтөлбөр**
- 61** Квотын санхүүжилт, зорилго
- 63** Ханбогд суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 79** Манлай суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 91** Баян-Овоо суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 98** Даланзадгад суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 104** Баяндалай суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 106** Сэврэй суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 124** Булган суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 128** Номгон суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
- 132** Цогт-Овоо суманд хуваарилагдсан квотын санхүүжилт, батлагдсан төсөл, хөтөлбөр
-
- 138 Сангийн ил тод байдал**
-
- 140 Сангийн хяналт, шинжилгээ-үнэлгээ**
-
- 150 Харилцагч байгууллагууд**
-
- 154 Санхүүгийн тайлан**
-
- 158 Төсөл хөтөлбөрүүдээс үр шим хүртэгчдийн сэтгэгдэл**

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Та бүхэнд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны үйл ажиллагааг танилцуулж байгаадаа баяртай байна.

Өмнөговь аймаг, “Оюу толгой” компанийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаанд суурилан бий болсон “Говийн оюу” ХДС-гаас санхүүжүүлэн говь нутгийн түмэн олны сайн сайхан амьдрал, орон нутгийн тогтвортой хөгжлийн төлөө хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд өргөжин тэлсээр байна.

“Оюутолгой” ХХК “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ” гэх алсын хараатайгаар Монголын говь нутагт эрдэм мэдлэг, ур чадварын уурхай босгож, эрдэс баялгаас үнэт зүйл бүтээн, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Энэхүү алсын хараа, эрхэм зорилгынхоо хүрээнд “Оюу толгой”-н үйл ажиллагаагаа явуулж буй нутаг болох Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан билээ. 2015 оны дөрөвдүгээр сарын 22-нд байгуулсан энэхүү гэрээг Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон хөрөнгө оруулагч “Рио Тинто” группийн олон улсад хэрэгжүүлдэг стандартын дагуу байгуулж, орон нутгийг тогтвортой хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зам, аргачлалаа тодорхойлсон юм.

Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх гол бүтэц “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ 2015 оны есдүгээр сард байгуулагдснаасаа хойш Хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлэн ажиллаж байна. “Оюутолгой” компани Хамтын ажиллагааны гэрээгээр өгсөн амлалтынхаа дагуу жил бүр таван сая ам.доллартай тэнцэх төгрөгийг “Говийн оюу” ХДС-аар дамжуулан Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулж байна.

Үүсгэн байгуулснаас өнөөг хүртэл уг сан нийт 36.7 тэрбум төгрөгөөр 78 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн, амжилттай хэрэгжүүлээд байна. Үүнд иргэдэд нэн хэрэгцээтэй байсан хүүхдийн цэцэрлэг, сургууль, сумдын хүн эмнэлэг, спорт заал, сумдын халаалтын уурын зуух зэрэг нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүдээс гадна иргэдийг чадавхжуулах, мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, сургалтын болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөгжлийн олон хөтөлбөр багтаж буй.

Ханбогд сумын сургууль, цэцэрлэгийн цогцолборыг ашиглалтад оруулсан нь 2018 оны онцлох ажил байлаа. Тус цогцолборыг шаардлагатай төхөөрөмж хэрэгслээр хангаж, бүрэн тохижуулсны зэрэгцээ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг “Шинэ-эрин” сургуультай менежментийн гэрээ байгуулан үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Түүнчлэн Даланзадгад сумд 100 хүүхдийн цэцэрлэг барих төслийг санхүүжүүлэв.

Энэ онд сангийн маань харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжиж НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Австралийн Элчин сайдын яам зэрэг байгууллагатай хамтран “Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр”, Германы эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөр” зэрэг томоохон хөтөлбөрийг санхүүжүүлж, амжилттай хэрэгжүүлж байна.

Сангийн санхүүжилтийг сумдад тэгш хүртээх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд түншлэгч болон уул уурхайгүй нийт есөн сумд санхүүжилтийн квот олгож, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллага хамтран сумандаа нэн шаардлагатай, нийгэмд хэрэгцээтэй төсөл хөтөлбөрийг санаачлан, сангийн дүрэм, журмын дагуу өөрсдөө сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх бололцоо олгосныг тэмдэглүүштэй. Энэ арга зарчим амжилттай хэрэгжиж зорилтот сумдын маань иргэд олон чухал төслийг санаачлан өөр өөрсдийнхөө сум, орон нутагтаа хэрэгжүүлснийг дурдахад таатай байна.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” маань цаашид ч Хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргээ чандлан биелүүлж, говь нутгийн хүн ардын амьдралыг дээшлүүлэхэд дэмжлэг болж ажиллах болно. Сангийн маань үйл ажиллагаа өргөжин, орон нутаг ба “Оюу толгой” компанийн харилцан итгэлцэл, хамтын ажиллагаагаар улам хөгжиж, хамтдаа итгэл төгс урагшилна гэдэгт итгэлтэй байгаагаар сангийн Харилцааны хороо, Удирдах зөвлөлийн өмнөөс болон хувиасаа илэрхийлье.

“Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ”

“Оюутолгой” ХХК-ийн Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал,
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн дарга



Тим Экерсли

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

АЛСЫН ХАРАА

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Өмнөговьчуудын сайн сайхан амьдралыг дэмжсэн хамтын хөгжлийн санаачллыг санхүүжүүлэгч сан байна

ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- Авилгалаас ангид байх
- Хувийн ашиг сонирхлоос ангид байх
- Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
- Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
- Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюутолгой” ХХК-ийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс **“Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан”** төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-д олгодог. “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь эрүүл мэнд, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэргээр аймгийн болон Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах зохион байгуулах зорилготой ажиллаж байна.

САНГИЙН ЗАСАГЛАЛ САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Сангийн эрх барих дээд байгууллага болох Удирдах зөвлөл нь Хамтын ажиллагааны гэрээний талууд болох Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон Оюутолгой компанийн төлөөлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй.

Сангийн хяналтын зөвлөлийн үүргийг хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх хэрэгжүүлдэг бол Гүйцэтгэх захиралаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлдэг.

Хуулийн хүрээнд байгуулсан дээрх бүтэцээс гадна талууд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд харилцан ойлголцол хамтын ажиллагааг дэмжих зохицуулах үүрэг бүхий Харилцааны хороог байгуулсан ба энэ нь Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх үүрэгтэй. Харилцааны хороо нь нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй, Оюутолгой компанийн төлөөлөл 4 гишүүн, орон нутгийн төлөөлөл 9 гишүүн сонгогдон ажиллаж байна. Оюутолгой компанийн төлөөллийг Хангамж, хүний нөөц сургалт,

байгаль орчин, орон нутгийн харилцаа гэсэн орон нутагтай илүү хамтран ажиллах шаардлагатай хэлтэс албадын төлөөлөл байдаг бол орон нутгийн зүгээс түншлэгч сумдын удирдлага, аймгийн салбар хариуцсан хэлтэс агентлагийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллаж байна. Оюутолгой компани болон орон нутгийн төлөөлөл тус бүрээс сонгогдсон Харилцааны хорооны хоёр дарга хурлыг ээлжлэн удирддаг.

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗАСАГЛАЛ

“Оюу толгой” ХХК, Өмнөговь аймаг, Ханбогд сумын хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу талуудын оролцоог хангах зорилгоор Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн бүтцэд Удирдах зөвлөл болон Харилцааны хороо гэх хоёр бүтцээр Өмнөговь аймагт нэн тэргүүний, хэрэгцээ шаардлагатай байгаа төсөл хөтөлбөрүүдийг хэлэлцүүлэн сонгон шалгаруулж, санхүүжилт олгох бүхий л үе шатанд орон нутаг болон “Оюу толгой” ХХК-ийн төлөөллүүд хамтран ажиллаж байна.

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Удирдах зөвлөл нь Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөл 7 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран орон нутгийн 3 гишүүнийг нэр дэвшүүлэх “Оюу толгой” ХХК-иас 4 гишүүнийг нэр дэвшүүлж Удирдах зөвлөлийг гишүүдийг томилдог.

Сангийн удирдлагыг сайжруулах болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн дүрмийн дагуу удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, сангийн дүрмийн хэрэгжилтийг сахиулах эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх томилогдон ажиллаж байгаа.



Тим Экерсли
Удирдах зөвлөлийн дарга



Б.Баяр
Сангийн Итгэмжлэгдсэн зөвлөх



Х.Сугир
УЗ-ийн Гишүүн



Н.Наранбаатар
УЗ-ийн Гишүүн



Б.Эрдэнэ-Очир
УЗ-ийн Гишүүн



Лаура Томас
УЗ-ийн Гишүүн



Д.Амарбаясгалан
УЗ-ийн Гишүүн



Ш.Байгалмаа
УЗ-ийн Гишүүн

ХАРИЛЦААНЫ ХОРОО

Сангийн Харилцааны хороо нь Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Өмнөговь аймаг, Оюу толгой ХХК болон сангаас хамтран ажиллах Түншлэгч сумдын харилцаа хамтын ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой бүтэц юм. Харилцааны хороо 13 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж орон нутгийн 9 төлөөлөгчийг томилж “Оюу толгой” ХХК-иас 4 гишүүнийг дараах байдлаар томилон ажиллаж байна.



Х.Батболд



Ш.Байгалмаа



Ө.Баянмөнх



Ж.Сүх-Эрдэнэ



Ү.Энхцэрал



О.Мандахбаяр



Ш.Эрдэнэжаргал



Г.Буянхүү



А.Оюунтуяа



В.Мөнхбат



М.Ариунтунгалаг



Д.Амартүвшин



Н.Эрдэнэбаяр


ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНД ХҮЛЭЭН АВАХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНАЛЫН ЧИГЛЭЛ

САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ



Хамтын ажиллагааны гэрээний дагуу Талууд үүрэг амлалт хүлээсэн ба Оюу толгой ХХК нь Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтууд болох нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжихгэсэн 7 Сэдэвчилсэн хавсралтаар төсөл хөтөлбөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх байдлаар Өмнөговь аймгийн тогтвортой хөгжил, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад зориулан жил бүр 5.0 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг Говийн оюу хөгжлийг дэмжих сангаар дамжуулан зарцуулахаар харилцан тохиролцсон.

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь иргэд байгууллагуудаас дээр дурьдсан нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ гэсэн 6 чиглэлийн Өмнөговь аймагт хэрэгжих төсөл хөтөлбөрийн санал хүлээн авч Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Өмнөговь аймагт нэн тэргүүд, хэрэгжүүлэх шаардлагатай төсөл хөтөлбөрийг шалгаруулж санхүүжилт олгодог.

Орон нутгийн бизнес хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалтын чиглэлийн төслүүдэд санхүүжилт олгохдоо бид ХААН банктэй гэрээ байгуулж бичил зээлийн үйлчилгээг хариуцуулснаар жил бүр бизнесээ шинээр эхлүүлэх болон өргөжүүлэх зорилготой Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдэд 50.0 сая хүртэлх төгрөгийн 1%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээл санал болгож төслийн уралдаан зарлаж шалгаруулж байгаа.




ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРИЛАЛТЫН СТРАТЕГИ 2018-2020



3 жилийн үндсэн чиглэл нь хүний хөгжилд чиглэсэн байна: Үнэлгээ, мэдлэг, ойлголт, ур чадвар нэмэгдүүлэх, зан төлөв, дадал зуршил өөрчлөх сургалт:

- Хөдөө аж ахуй
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Бизнес хөгжил



Зорилтот газар

- 1 ✓ ОТ Түншлэгч сумд-4
- 2 ✓ Уул уурхайгүй сум-5
- 3 ✓ Бусад сум-6

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь 2017-2018 онд IRIM Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран Хамтын ажиллагааны гэрээний 7 сэдэвчилсэн хавсралт, чиглэлийн дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж уг чиглэлүүдийн хүрээнд Өмнөговь аймагт нэн тэргүүнд тулгараад байгаа асуудлуудыг тодорхойлж Сангийн 3 жилийн үндсэн чиглэл, стратегийг боловсруулж Харилцааны хороо болон Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засагт хувь нэмр оруулах хүсэлтэй иргэд байгууллага, хоршоо нөхөрлөл нь Сангаас жил бүр Түншлэгч сум (Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад) болон уул уурхайгүй сумдад (Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газраас жил бүр тодорхойлсны дагуу) олгох квотын санхүүжилтээр төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж болох байдлаар Сангийн Удирдах зөвлөл шийдвэр гарган хэрэгжүүлж эхлээд байна. Дээр дурдсан стратегийн дагуу Говийн оюу хөгжлийг дэмжих сан нь 2018 оны 2-р улирлаас хойш төсөл хөтөлбөрийн санал хүлээн авахаа зогсоож Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр хэрэгжүүлэхээр баталсан гурван жилийн стратеги төлөвлөгөөг ээлж дараалалтай хэрэгжүүлэхээр орон нутгийн саналд тулгуурлан Ажлын даалгавар боловсруулан төслийн уралдаан зарлан шалгаруулж хэрэгжүүлж эхлээд байна.

Сан нь төсөл зарлах үйл явцаа нийгмийн дэд бүтцийн төсөл болон тогтвортой хөгжлийн хөтөлбөр гэсэн 2 төрлөөр тодорхойлсон. Нийгмийн дэд бүтцийн шинж чанартай Өмнөговь аймагт бий болгох бүтээн байгуулалтын төслүүдийг сонгохдоо аймгийн ЗДТГ-аас санал хүлээн авсны дагуу судалгаа шинжилгээ дээр үндэслэх бөгөөд Сангаас санхүүжүүлэх нийгмийн дэд бүтцийн төсөл бүрд зураг төсөл, менежмент болон үйл ажиллагааны зардлыг бүрэн шийдсэн байхаар тодорхойлно. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхдээ 3 жилийн стратегид тусгагдсан чиглэлийн дагуу жил бүр төслийн уралдаан зарлаж шалгуурт нийцсэн төсөл хэрэгжүүлэгчийг сонгож хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь Хамтын ажиллагааны гэрээний зорилгод хүрч ажиллахын тулд Санхүүжилтийн удирдамжинд заасны дагуу жилийн нийт санхүүжилтийнхээ 5%-ийг Өмнөговийн ирээдүй хойч үеийнхэнд зориулан хуваарилдаг. Энэхүү хойч үедээ зориулсан сан нь эргэлтийн сангийн хэлбэртэй байх бөгөөд Говийн оюу- Бизнес боломж бизнесийн бичил зээл, Говийн оюу -Хадгаламж, Говийн оюу-Оюутны тэтгэлэг гэсэн үндсэн гурван чиглэлд хуваарилагдан зарцуулагдаж байна.

“ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” БИЗНЕСИЙН БИЧИЛ ЗЭЭЛ

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь 2016 оноос хойш “Говийн оюу – Бизнес боломж” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2018 онд уг хөтөлбөрийн хүрээнд нийт 692,284,298 төгрөгийг бичил зээлийн эх үүсвэрт байршуулсан ба одоогийн байдлаар Түншлэгч сумд (Ханбогд, Баян-Овоо, Даланзадгад, Манлай)-ын 32 бизнес эрхлэгч иргэдийг дэмжиж зээл олгоод байна. Одоогийн байдлаар бичил зээлийн хөтөлбөр нь 3 дахь жилдээ амжилттай хэрэгжиж нийт 668,020,000 төгрөгийн зээл олгосон.

Зээл авсан бизнес эрхлэгчдийн харьяалал


Сум	Зээлийн тоо	Олгосон зээл
Даланзадгад	18	380,000,000
Ханбогд	9	171,000,000
Манлай	4	79,020,000
Ханхонгор	1	30,000,000
Нийт	32	668,020,000

Олгосон бичил зээлийн зориулалт

Зээлийн зориулалт	Зээлийн тоо
Хүнсний худалдаа, дэлгүүрийн өргөтгөл	7
Гутал засвар, оёдол	2
Үйлдвэрлэл, үйлчилгээ	6
Аялал жуулчлал	1
Авто засварын үйлчилгээ	1
Барилгын материалын үйлдвэрлэл	14
Хөдөө аж ахуйн чиглэлээр	1
Нийт	32

Нийт олгосон зээлийг бизнесийн салбараар нь авч үзвэл 48% нь үйлдвэрлэлийн, 28.7% нь үйлчилгээний, үлдэх 23.3% нь худалдааны салбарт тус тус зориулагдсан байна.

Графикаар харуулбал:



Олгосон зээл эзлэх хувь

Нийт олгосон зээлийн 48% буюу үйлдвэрлэлийн салбарт олгогдсон зээл нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд түлхэц болсон.

Үйлдвэрлэлийн салбарт олгосон зээл

Төсөл хэрэгжүүлэгч Г.Доржсүрэн. Уг харилцагч нь Даланзадгад суманд 2016 оноос вакуум цонхны үйлдвэрлэл эрхэлж байгаа. Уг харилцагч нь үйл ажиллагаагаа түрээсийн байранд явуулдаг байсан ба



Үйлдвэрлэлээ явуулах барилга худалдан авах зорилгоор 30,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдсан. Өөрийн үйлдвэрийн байртай болсноор, үйлдвэрлэл явуулах зай талбай том болж, тоног төхөөрөмж нэмж авсан. Үйл ажиллагаагаа өргөжүүлж шинээр 2 ажлын байр бий болгосноос гадна үйлдвэрийн бүтээмж нэмэгдсэн.



Төсөл хэрэгжүүлэгч Ж.Батмөнх. Уг харилцагч нь 2014 оноос хойш Ханбогд суманд барилгын үндсэн материал болох блок үйлдвэрлэж байгаа. Үйлдвэрлэлийн дамжлагыг сайжруулах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх үүднээс 15,000,000 төгрөгийн төслийн зээл авч шинээр кольцо үйлдвэрлэх хэв болон бетон зуурагч машин худалдан авсан. Төслийн зээлд хамрагдсанаар шинээр 4 ажлын байр бий болгосон.



Төсөл хэрэгжүүлэгч Б.Энхтайван. Уг харилцагч нь Ханбогд суманд 2016 оноос хойш гэрийн тавилга үйлдвэрлэж байгаа. Үйлдвэрийн байрны зай талбайг томруулах зорилгоор 7*10м-ийн харьцаатай ажлын байр шинээр барихаар 15,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг 2018 оны 9 дүгээр сард авсан. Одоогоор ажлын байраа барьж дууссан.



Төсөл хэрэгжүүлэгч Ж.Хатанбаатар. Уг харилцагч нь 2010 оноос эхлэн Даланзадгад суманд вакуум цонхны үйлдвэрлэл явуулж байгаа ба үйл ажиллагаандаа зориулан 15,500,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл, 5,000,000 төгрөгийн эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх төслийн зээлийг тус тус авсан. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор тавилгын үйлдвэрлэлийн



зориулалттай барилга барьж ашиглалтад оруулан, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхэлсэн. Төслийн зээлд хамрагдсанаар шинээр 4 ажлын байр бий болгосон.

Худалдааны салбарт олгосон зээл

Төсөл хэрэгжүүлэгч И.Үүрийнтуяа нь 2013 оноос эхлэн Ханбогд суманд эмийн сан ажиллуулж байгаа, Төслийн зээлд хамрагдсанаар үйлчлүүлэгчдэдээ ая тухтай орчинд үйл ажиллагаагаа явуулах зорилгоор тохижилт хийснээс гадна шинээр нярай хүүхдэд зориулсан тасаг нээсэн, мөн даралтны аппарат, хүчилтөрөгчийн коктейлийн аппарат зэргийг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг эмийн сан нь Ханбогд сумын нийт ханган нийлүүлэлтийн 30% хувийг хийдэг.



Төсөл хэрэгжүүлэгч Ж.Баттулга нь Ханбогд сумын төвд 2008 оноос хойш “Ханбулаг” бөөний төв болон зочид буудал ажиллуулж байгаа. Уг харилцагч нь бөөний төвийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 30,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдсан.

Төслийн зээлд хамрагдсанаар худалдаж буй бараа нэр төрлөө нэмэгдүүлж шинээр хүүхдийн тоглоомын тасгийг нээн ажиллуулж байна.



Төсөл хэрэгжүүлэгч Б.Мөнхтуяа нь Ханбогд суманд 2011 оноос “Мөнх гоёл” оёдлын салон болон бөс барааны худалдаа эрхэлж байгаа. Бизнесийн үйл ажиллагаандаа зориулан 5,000,000 төгрөгийн зээл, 25,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг тус тус авсан.



Хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсанаар үйлдвэрийн барилгаа өргөтгөж шинээр тоног төхөөрөмж нэмж авсан. “Мөнх гоёл” салон нь Ханбогд сумын ард иргэдэд үндэсний хувцас (эмэгтэй дээл, эрэгтэй дээл, монгол цамц, хүрэм хантааз, дан дээл, загварын дээл), европ хувцас (пальто, өмд, пудволк, цамц, пиджак, костюм, даашинз, гоёлын даашинз) хийж үйлчилдэг.



Дээрх төслийн зээлд хамрагдсан нийт харилцагчид зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж өрхийн орлогоо нэмэгдүүлж чадсан.


ГОВИЙН ОЮУ - ХАДГАЛАМЖ

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь Өмнөговь аймгийн ирээдүйн эзэд хүүхэд залуучуудад зориулан жил бүрийн нийт санхүүжилтийнхээ 2%-ийг 10 жилийн хугацаатай хадгаламжид байршуулж байна. Уг хадгаламжийг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр нээж одоогийн байдлаар 692.3 сая төгрөг хуримтлуулаад байна.

“ГОВИЙН ОЮУ - ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨР


Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу – Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2018 онд 3 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас Өмнөговь аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсэний дагуу аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” болон Өмнөговь аймагт боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөлөөс бүрдсэн сонгон шалгаруулах хороо байгуулагдаж, 2018-2019 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2018 онд улсын болон магадлан итгэмжлэгдсэн сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 55 оюутанд 2018-2019 оны хичээлийн жилийн эхний хагас жилд 73,599,220 төгрөгийн тэтгэлэг олгосон.



“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт 2016 онд 30, 2017 онд 57, 2018 онд 55 оюутан тус тус хамруулсан бөгөөд 2016-2018 онд Өмнөговь аймгийн 142 оюутанд 262.2 сая төгрөгийн тэтгэлэг олгоод байна.

Жил бүр Өмнөговь аймагт шаардлагатай байгаа мэргэжлээр сурч буй оюутнуудад хөрөнгө оруулалт хийж байна.



2018 ОНД “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУД




БАТЛАГДСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ


УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН САНАЛУУД

2018 онд Говийн Оюу хөгжлийг дэмжих санд нийт 38 төслийн санал ирснээс Сангийн Удирдах зөвлөл Сангийн санхүүжилтийн удирдамж, шалгуур, Өмнөговь аймгийн нэн тэргүүний чиглэлтэй нийцсэн 13 төсөл хөтөлбөрийн саналыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.


Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн 2018 онд хүлээн авсан төсөл хөтөлбөрийг чиглэлээр нь дараах байдлаар харуулж байна.




Говийн Оюу хөгжлийг дэмжих сангаас 2018 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хуваарилалтыг дараах байдлаар харуулж байна.




ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН СТАТИСТИК МЭДЭЭ, 2015-2018 ОНД ӨМНӨГОВЬ АЙМАГТ ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Батлагдсан төслийг сэдэвчилсэн хавсралтаар харуулав (2015-2018)



Зорилтот үр шим хүртэгчид



	Хүүхэд	Эмэгтэйчүүд	Залуучууд	Малчин	Ахмад настан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
2015	600					
2016	6486	1000	18450	6971	38	
2017	7627	163	840	531	4400	300

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮД

ИРГЭДИЙН АМЬДРАХ орчныг
сайжруулсан

1.3 ТЭРБУМ ₮
539.5 СЯА АМ. ДОЛЛАР

2 сумын уурын зуух



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАЛЫН ЭРҮҮЛ
МЭНДЭД ХӨРӨНГӨ ОРУУЛСАН

1.4 ТЭРБУМ ₮
583 МЯН АМ. ДОЛААР

Сум дундын малын эрүүл
мэндийн төв



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛСАН

2.3 ТЭРБУМ ₮
966.8 МЯН АМ. ДОЛЛАР

2 эмнэлгийн барилга, 1 эмнэлгийн зураг
төслийн ажил



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛСАН

13.4 ТЭРБУМ ₮
5.6 СЯА АМ. ДОЛЛАР

3 цэцэрлэг, сургууль цэцэрлэгийн комплекс,
спорт заал, дотуур байрны зураг төслийн ажил



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ӨВ СОЁЛЫГ
ХАМГААЛАХАД ХӨРӨНГӨ ОРУУЛСАН

5.7 ТЭРБУМ ₮
2.4 СЯА АМ. ДОЛЛАР

Өмнөговь аймгийн музей



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН САЛБАРТ
ХӨРӨНГӨ ОРУУЛСАН**
2.3 ТЭРБУМ ₮
972 МЯН АМ. ДОЛЛАР

Цахим багш, Ирээдүйд гэрэлтэх нас,
Эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл
мэндийг дэмжих хөтөлбөр



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛСАН**

1.3 ТЭРБУМ ₮
555 МЯН АМ. ДОЛЛАР

Говийн бүсийн сэргээн засах
үйлчилгээ, шүдний кабинет тохижуулах



**ХОГ ХАЯГДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ
САЙЖРУУЛАХАД ХӨРӨНГӨ ОРУУЛСАН**

1.2 ТЭРБУМ ₮
540 МЯН АМ. ДОЛЛАР

2 сумын хог хаягдлын менежмент,
мод үржүүлэг



**АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ
ХӨРӨНГӨ ОРУУЛСАН**

323 САЯ ₮
134.6 МЯН АМ. ДОЛЛАР

Ариутгал- 2016, Шилмэл сүрэг



**АЙМГИЙН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ САЙЖРУУЛАХАД
ХӨРӨНГӨ ОРУУЛСАН**

524.9 САЯ ₮
218.7 МЯН АМ. ДОЛЛАР

Тариа, Бэлчээр эрдэнэ



САНГИЙН 2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ



Удирдах зөвлөлийн хурал

- 2018.03.15
- 2018.07.04



ХДС-ийг танилцуулах үйл ажиллагаа

- 2018.03.15



Зорилтот сумдад квотын санхүүжилт олгож эхлэв

- 2018.03.28-29- Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Номгон, Булган, Цогт-Овоо сумдын засаг дарга нартай квотын санхүүжилт олгох гэрээ байгуулав



Хамтарсан хөтөлбөр

- 2018.04.27- НҮБ-тэй хамтран Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн гэрээ байгуулав



Хөндлөнгийн Аудит хийлгэв

- 2018.05.29



Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолбор ашиглалтанд оров

- 2018.12.05- ХДС-ийн хамгийн өндөр санхүүжилттэй төсөл



Говийн Оюу-Оюутны тэтгэлэг

- 2018.09.09- 55 оюутан тэтгэлэгт хамрагдсан



Хамтарсан хөтөлбөр

- 2018.05.17- GIZ, IFC тэй хамтран Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийн гэрээ байгуулав



Харилцааны хороо хурал

- 2018.03.02
- 2018.06.19
- 2018.08.28

УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНГИЙН 2018 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУВААРИЛСАН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Санхүүжилт
Нийгмийн дэд бүтэц		
1	Өмнөговь аймийн музей	3,500,000,000
2	Мандал-Овоо сумын 10 ортой эмнэлэг	1,199,126,939
3	11-р цэцэрлэг	998,573,645
4	Манлай сумын эрүүл мэндийн төвийн зураг төслийн ажил	33,091,531
Дэд дүн		5,730,792,115
Байгаль орчны менежмент		
1	Хөрс эрдэнэ	104,528,163
Дэд дүн		104,528,163
Нийгмийн суурь үйлчилгээ		
1	Хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр	16,855,555
2	Уул уурхайн салбарын ажиллах хүчин бэлтгэх хөтөлбөр	183,900,000
3	Дотуур байр-хүүхдийн ээлтэй орчин	110,183,448
4	Багшийн хөгжил-ур чадвар	158,915,000
5	Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин	248,379,240
6	Өмнөговь аймгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	995,787,309
7	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн нэмэлт ажил-тоног төхөөрөмж	1,100,000,000
Дэд дүн		2,814,020,552
Усны менежмент		
1	Чандмань эрдэнэ	641,679,123
Дэд дүн		641,679,123
Орон нутгийн бизнес хөгжил		
1	Өмнөговь аймгийн ЖДБ-ийг дэмжих	608,417,500
Дэд дүн		608,417,500
Бусад		
1	Квотын санхүүжил	900,457,900
2	Хандив тусламж	243,367,000
3	Ирээдүй хойч үеийн төлөө сан	608,417,500
4	ХДС-ийн үйл ажиллагааны зардал	601,136,839
Дэд дүн		2,353,379,239
НИЙТ ДҮН		12,252,816,692

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН 100 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА БАРИХ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“СУВАРГАН ГОВЬ” ХХК

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

1,730,339,396 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

1,448,573,645 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сумын 11-р цэцэрлэгийн үндсэн барилга нь 1980 онд ашиглалтад орсон 75 хүүхдийн багтаамжтай юм. Тус цэцэрлэгийн хамран сургах хүүхдийн тоо нь цэцэрлэгийн хүчин чадлаас 2-3 дахин олон болсон тул Даланзадгадын 1-р сургуулийн дотуур байрны барилгыг ашиглаж нэмэлтээр 3 бүлэг нээн ажиллуулж нийт 219 хүүхдийг сурган хүмүүжүүлж байв. Хүүхдүүдийн олонх нь дотуур байрны барилгад буюу зориулалтын бус байранд цэцэрлэгт хамрагдаж байснаас гадна 11-р цэцэрлэгийн барилга нь урлаг, биеийн тамир, хоолны заалгүй баригдсанаас шалтгаалж стандартын бус өрөөг тохижуулан хоолны заал болгон ашиглаж байсан. Дотуур байрны барилгад мөн сургуулийн бага ангийн сурагчид хичээллэх болж,

цэцэрлэгт ашиглуулах боломжгүй болсон зэргээс үүдэн улсын тэргүүний 11-р цэцэрлэгийн үндсэн барилгатай залган өргөтгөл байдлаар 100 хүүхдийн цэцэрлэг барих шаардлагатай болсон.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Зориулалтын бус, өөр байгууллагын өмчлөлийн барилгад салбар нээснээс үүдэн хоёр тусгай газар үйл ажиллагаа явуулж байсан цэцэрлэгийн үйл ажиллагааг нэг дор төвлөрүүлэн стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн орчин бүрдүүлэх
- Анги дүүргэлт 43.2 байгааг стандартад нийцүүлэн 25-30 хүүхэдтэй болгох

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

С.Удвалын нэрэмжит улсын тэргүүний 11-р цэцэрлэгийг түшиглэн 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн 2 давхар барилгыг батлагдсан зураг төсвийн дагуу барьж улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулах.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар тогтоолоор Даланзадгадын 11-р цэцэрлэгийн дэргэдэх 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих төслийг санхүүжүүлэхээр батлав.
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч аймгийн ЗДТГ болон захиалагчийн шалгаруулсан гүйцэтгэгч “Суварган говь” компанитай санхүүжилтийн гэрээ байгуулав
- 2018 оны 3 сарын 18 ны өдөр цэцэрлэгийн барилгын шав тавих ёслол болж, Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч Х.Батболд, “Оюутолгой” ХХК-ийн Өмнөговь аймаг дахь төлөөлөгчийн газрын менежер Д.Олжмэдэх, Гүйцэтгэгч компанийн удирдлага, барилгачид, эцэг эхийн төлөөлөл оролцлоо.
- 2018 оны 9 сарын 12 нд шинэхэн цэцэрлэгийн нээлтийн ёслолын үйл ажиллагаа болж Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар, Оюутолгой ХХК-ийн Орон нутгийн харилцааны ерөнхий менежер Ш.Байгалмаа, гүйцэтгэгч “Суварган говь” ХХК-ийн захирал Бямбадорж, цэцэрлэгчийн эрхлэгч Ж.Зул болон багш сурган хүмүүжүүлэгчид, тус цэцэрлэгийн ахмад багш нар, эцэг эхчүүд оролцож цэцэрлэгийн авьяаслаг бяцхан багачуул ая дууныхаа дээжээр шинэхэн цэцэрлэгээ мялааж ирсэн зочдын сонорыг баясгав.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Зориулалтын хоолны болон урлаг, биеийн тамирын заалтай стандарт хангасан байранд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлсэн
- Хамран сургах тойргийн хүүхдүүд сургуулиас өмнөх боловсрол эзэмших нөхцөл бүрдсэн
- Шинээр 2 ажлын байр бий болсон.

- Орон нутгийн компани барилга угсралтын ажлыг чанартай гүйцэтгэж, орон нутгийн зах зээлээс барилгын материал түүхий эд худалдан авч нэмүү өртөг бий болгон орон нутгийн төсөвт татвар төлсөн.
- Барилга угсралтын явцад түр ажлын байр 34.
- Цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтад орсноор сургуулийн барилга суларч сургууль нь сургалтын болон бусад зорилгоор ашиглах бололцоо бүрдэнэ.
- Гүйцэтгэгч компани барилга угсралтын ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 160 хүүхэд шинээр цэцэрлэгт хамрагдаж, эцэг эхчүүд хүүхдээ эрүүл аюулгүй орчинд хүмүүжүүлж, өөрсдөө ахуй амьдралаа дээшлүүлэх, ажил хөдөлмөрөө энхрий үрсдээ санаа зовох зүйлгүй хийх боломж бүрдэв.
- Барилга угсралтын ажлын явцад орон нутгаас үндсэн болох туслах ажилтан нийт 30 /үндсэн 18, туслах 12/, бусад түр ажлын байр 34, нийт 64 ажилчин ажилласан байна. Мөн орон нутгийн зах зээлээс 700 шоо метр бетон зуурмаг -129.5 сая төгрөг, 150тн цемент -33.0 сая төгрөг, 530 шоо метрдүүргэгч - 3,9 сая нийт 166,5 сая төгрөгийн худалдан авалт хийж орон нутагторлого оруулсан.

МАНЛАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЗУРАГ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

"БЕСТ ДИЗАЙН КОНСТРАКШН" ХХК

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

35,000,000 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

33,091,531 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын Эрүүл мэндийн төв нь 1938 онд байгуулагдсан бөгөөд 2018 онд 80 жилийн ойтойгоо золгож байна. Манлай сумынхаа ууган, гол байгууллагуудын нэг бөгөөд орон нутгийнхаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажилладаг. 1997 онд ашиглалтанд орсон хуучин барилга нь өнөөгийн стандарт шаардлага хангахгүй болсон, ариутгал, угаалга зэрэг зохион байгуулалт буруу зэрэг нь халдвар хамгааллын дэглэмийг зөрчдөг, эмнэлгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэдэг. Өмнөговь аймгийн хамгийн зүүн захад байрладаг Манлай сумын газар зүйн байршлаас шалтгаалан иргэд, малчид тэр бүр аймгийн төв болон бусад нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлж үйлчилгээ аваад байх бололцоо муутай, сумын уугуул 2600 аад иргэдээс гадна хөдөлгөөнт хүн ам ихээхэн нэмэгдэж тэдэнд зориулсан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, уг үйлчилгээг хүргэх суурь нөхцөл болсон эмнэлгийн барилга, хүчин чадал, орчныг сайжруулах шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Орчин үеийн шаардлага хангасан эмнэлгийн барилгын зураг төсөл хийлгэж, тусгай мэргэжилтнээр батлуулан бэлэн болгох

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Манлай сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилгын зураг төсөл хийлгэх төслийг дэмжиж санхүүжилтийг батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу Захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Бест дизайн констракшн” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гэрээ байгуулснаар зураг төслийн ажлыг эхлүүлэв.

ҮР ДҮН:

Гүйцэтгэгч “Бест дизайн констракшн” компани захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, Манлай сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллаж зураг төслийн ажлыг гэрээний дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгэж тусгай мэргэжилтнээр батлуулав.

Ингэснээр Өмнөговь аймгийн Манлай суманд хүн ардын эрүүл энхийн төлөө цаг наргүй ажилладаг Эрүүл мэндийн төв шинээр бариулах барилгын бэлэн зураг, төсөлтэй боллоо.

“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“АГЛУТ” ХХК

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

6,940,985,194 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

5,795,000,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд хэсэгт говийн үзэсгэлэнт байгальтай, говь нутгийн байгаль цаг агаарт зохицсон уламжлалт нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын арвин уламжлалтай нутаг юм. Байгалийн өвөрмөц тогтоц нь, үзэсгэлэнт газрыг түшиглэсэн аялал жуулчлал нь аймгийн эдийн засгийн тулгуур салбарын нэг юм. Монгол улсад ирж буй жуулчдын 80 гаруй хувь нь говь нутгийг үзэж сонирхохоор ирдэг. Эдгээр жуулчдад нутаг орны соёлын өв, говь нутгийн нэрийн хуудас болсон үлэг гүрвэл олдвор зэрэг палеонтологийн ховор нандин үзмэрүүдийг үзүүлэхэд аймгийн музейн одоогийн барилгын хүчин чадал хаана нь ч хүрдэггүй. Учир нь музейн барилга нь 1954 онд чулуугаар барьсан аймгийн анхны зочид буудал бөгөөд 1969 онд аж ахуйн аргаар хоёр давхар болгосон. Барилгад суулт өгч хана цуурсан зэрэг эвдрэл гэмтэл нь музейн үйл ажиллагаанд тавигдах MNS 5634:2006 стандартын шаардлага хангахгүй, үзмэрүүдийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж байдаг.

Энэ нөхцөл байдлын улмаас барилгын болон галын улсын байцаагчийн дөрвөн удаагийн дүгнэлтээр үйл ажиллагааг зогсоох шаардлага тавигдаад байгаа. Иймд уг барилгыг музейн зориулалтаар цаашид ашиглах боломжгүй болоод байгаа юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь Стандартын шаардлага хангасан, барилга архитекторын өвөрмөц шийдэл бүхий музейн барилга барьж ашиглалтад оруулна. Ингэснээр Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгох, гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулах.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15- ны өдрийн 06 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Музейн барилга төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Аглут” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- Барилга угсралтын ажил 2018 оны эцсийн байдлаар 40 хувьд хүрэв.
- 2018 оны байдлаар орон нутгийн зах зээлээс 246 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн авч, 58 түр болон байнгын ажлын байр бий болсон

ҮР ДҮН:

- Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгоход музей чухал үүрэг гүйцэтгэнэ
- Гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчлан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулна.

“МАНДАЛ-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ШИНЭ БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ХОС БОР МОРЬ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	1,740,806,062 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	1,199,126,939 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-овоо сум нь Өмнөговь аймгийн хамгийн хойд захын сум бөгөөд уламжлалт мал аж ахуйгаас өөр эдийн засгийн тулгуур багатай, аймгийн төвөөс алслагдсан сум юм. Тус сумын хүн эмнэлэг нь 1938 онд байгуулагдсан ба одоогийн ашиглаж байгаа барилга нь 1979 онд ашиглалтад орсон чулуу, бетон суурьтай, тоосгон ханатай модон хучилттай нэг давхар барилга.

Барилгын төмөр дээвэр олон жилийн эдэлгээ, зэврэлтийн улмаас цоорч дээврийн битүү байдал алдагдсан, цас борооны ус байнга нэвчдэг, барилгын дам нуруу, хучилт зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хотойлтод орсон, модон хучилтын бамбай цөмөрч унасан зэрэг асуудал нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх стандарт хангагдаагүйгээс эмнэлгийн дотор халдвар дамжих, барилга ашиглалтын явцад иргэдийн эрүүл мэнд амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд аюул учруулах өндөр эрсдэлтэй. 2017 онд Мэргэжлийн хяналтын байгууллага уг барилгыг ашиглалтын шаардлага хангахгүй

хэмээн дүгнэсэн. Иймд эмнэлгийн стандарт, магадлан итгэмжлэлийн шалгуур хангахгүй болсон тус төвийг шинэчилж, сумын иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэвийн нөхцөлд үзүүлэх бололцоог бүрдүүлэхийн тулд стандартад нийцсэн эмнэлгийн барилга барих шаардлагатай.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Мандал-овоо сумын хүн амд үзүүлдэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх орчин үеийн стандарт шаардлага хангасан эмнэлгийг барилга барьж ашиглалтад оруулах

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15 ны өдрийн 06 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих төслийг дэмжиж санхүүжилтийг нь батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хос бор морь” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” анхүүжилтийн гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

ҮР ДҮН:

- Мандал-овоо сумын эрүүл мэндийн төв стандарт шаардлага хангасан шинэ барилгатай болж орон нутгийн иргэд болон явуулын хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, чанартай хүртээмжтэй хүргэх бололцоо бүрдсэн
- Мандал-овоо сумын эрүүл мэндийн төвийн 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний босгон дээр барилгын шав тавих ёслол зохион байгуулж, уг арга хэмжээнд нутгийн иргэд, ахмад эмч нар, үе үеийн эмч эмнэлгийн ажилтнууд, орон нутгийн удирдлага, хөрөнгө оруулагч “Оюу Толгой” компанийн төлөөлөл оролцов.



“ХАНБОГД СУМЫН СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ-МЕНЕЖМЕНТИЙН ЗАРДАЛ” ТӨСӨЛ



САНААЧЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЭНХБОДИЗ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	1,000,000,000 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	970,454,620 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2016 оны 08 тогтоолоор Ханбогд сумын “600 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн цогцолбор” төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэж уг цогцолбор барилгын гүйцэтгэгчээр Говийн өгөөж компани шалгаран санхүүжилтийн гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Уг цогцолбор барилгыг зориултын дагуу иж бүрэн ашиглахад сургууль цэцэрлэгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах хэрэгтэй болсон.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр Ханбогд суманд баригдаж буй сургууль цэцэрлэгийн цогцолборт Ханбогд сумын ЗДТГ-ын санаачилсан, аймгийн ЗДТГ-ын захиалгатай төслийн дагуу 637 төрлийн нийт 10644 ширхэг багаж, тоног төхөөрөмж нийлүүлнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолбор барилгад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх төслийг “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 06 тогтоолоор дэмжиж, тоног төхөөрөмж болон менежментийн зардалд нийт 1,100,000,000 төгрөг батлав.
- Захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Энхбодиз” ХХК тай гэрээ байгуулсны дагуу “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Энхбодиз” ХХК-тай санхүүжилтийн гуравласан гэрээ байгуулж тоног төхөөрөмж худалдан авч нийлүүлэх үйл ажиллагааг эхлүүлэв.

ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр баригдсан 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэг нь орчин үеийн стандарт шаардлага хангасан тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүн зэрэг сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр 100 хувь хангагдсан
- Шинээр барьсан сургууль цэцэрлэгийн цогцолбор зориулалтын дагуу бүрэн ашиглагдах бололцоотой болсон.
- 640 хүүхэд шинэ хичээлийн байртай болж ээлжээр хичээллэх шаардлагагүй болсон тул хичээлийн бус цагаар сургалт хүмүүжлийн олон талт нэмэлт үйл ажиллагаанд хамрагдах бололцоотой болсон
- Шинэ сургууль цэцэрлэг ашиглалтанд орсноор 91 ажлын байр бий болов.

ХАМГИЙН ГОЛ ҮР ДҮН

- Ханбогд суманд төдийгүй Өмнөговь аймагт анх удаагаа хөдөөгийн сумын сургуульд Улаанбаатар хотын шилдэг сургууль болох олон улсын стандартаар сургалтаа явуулдаг лаборатори “Шинэ-Эрин” сургуулийн менежментийн баг ажиллахаар болов. Тус сургуулийн багш нар сургалтын шинэ стандарт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, цахимаар Ханбогдын сургуулийн багш нарт сургалт орж хамтран ажиллах юм.

2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР:

“ХӨРС ЭРДЭНЭ” ХӨТӨЛБӨР



САНААЧЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“СОДОН ЭРЧИС” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	108,225,200 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	104,528,163 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сум 2013 онд сумынхаа ахмадууд болон газар тариалан эрхлэгчдээ дэмжиж газар тариалангийн жишиг талбайг “Оюутолгой” ХХК-тай хамтран байгуулсан. Энэхүү талбай нь сумын төвөөс алслагдсан байршилтай тул цахилгааны эх үүсвэргүй, усалгааны зориулалтаар мотор ажиллуулахад их хэмжээний зардал гаргадаг сул талтай. Иймд уг тариалангийн талбайруу сумын цэвэр усны нөөцийн трансформатораас цахилгааны шугам татаж эрчим хүчээр хангах шаардлагатай.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Тариалангийн талбайг цахилгаан эрчим хүчээр хангахын тулд сумын төвөөс 10кВт -ын цахилгаан дамжуулах 3.2 км шугам татаж 10/04 кВт-ын дэд станц барьж байгуулна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Баян-Овоо сумын ЗДТГ-аас санаачилсан уг төслийг сангийн ажлын албанд хүлээн авч Харилцааны хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжсэний дагуу Удирдах зөвлөлийн хуралд танилцуулав.

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын хурлаар дэмжигдэж нийт 108.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.

Захиалагч Баян-Овоо сумын ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зарлаж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, 757/18 дугаартай эрчим хүчний тусгай зөвшөөрөл бүхий “Содон-Эрчис” ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулж ажил гүйцэтгэх гэрээ байгуулав.

Санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч болон гүйцэтгэгч байгууллагуудтай дээрх гэрээг үндэслэн гэрээ байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.

Гүйцэтгэгч “Содон эрчис” ХХК гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд ажлаа гүйцэтгэж, хяналтын болон хүлээн авах комисс ажилласнаар уг төсөл амжилттай хэрэгжлээ.

ҮР ДҮН:

Уг төсөл хэрэгжсэнээр:

- Баян-Овоо сумын газар тариалангийн зориулалтын талбай байнгын гэрэл цахилгаантай болж талбайн усалгааны зардал буурна
- Газар тариалан эрхлэгчдийн хөдөлмөрийг хөнгөвчилж орлого нэмэгдэх нөхцөл бүрдэв.
- Газар тариалан, хүнсний ногоо тарихыг хүссэн хүмүүс шинээр ажлын байртай болох, орлого олох амьжиргаагаа дээшлүүлэх болоцоо нэмэгдэв
- Баян-Овоочууд өөрсдийн газар шороондоо ургуулсан хүнсний ногоогоор хэрэгцээнийхээ багагүй хэсгийг хангах, улмаар бусад зах зээлд борлуулах боломжтой болов.

2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР:

“ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР



САНААЧЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД
СУМЫН 25-Р ЦЭЦЭРЛЭГ**

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ЭРХЭТ РАЙ” ХХК

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

20,000,000 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

16,855,555 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сумын 25-р цэцэрлэг нь “Оюутолгой” ХХК-ийн хөрөнгө оруулалттай “Говийн Оюу хөгжлийг дэмжих санг”-ийн санхүүжилтээр баригдаж үйл ажиллагаагаа явуулж байгаа. Шинэ тутам цэцэрлэгийн хувьд хүүхдийн сургалтын орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдаж чадахгүй байгаа.

Бага насны хүүхдийн тархины хөгжилд хөдөлгөөн чухал үүрэг гүйцэтгэдэг. Орчин үеийн хүүхдийн тоглох тоглоом нь сууж тоглоход зориулагдсан, хөдөлгөөний хомсдол үүсгэхээр цахим тоглоом давамгайлж хамтаараа, олуулаа хамтран тоглох хөдөлгөөнт тоглоом дутмаг байна. Ихэнх гэр бүлд хүүхдийн тоо цөөрч, хүүхэдтэй хамтран тоглох байдал дутмаг, зурагт, компьютер, гар утас зэрэг мэдээллийн техник хэрэгслийн ард хэт суулгах, хөдөлгөөн хязгаарлагдмал байдалд байлгах нь

ихэссэн. Хүүхдүүдийн дунд жингийн илүүдэл нэмэгдэж бие бялдрын хөгжлийн хурд, авхаалж самбаа, уян хатан, тэсвэр хатуужил зэрэг чадвар доогуур үзүүлэлттэй байна.

Иймд хүүхдийн бие бялдар, эрүүл мэндийг дэмжин хөгжүүлэх, эрчимтэй хөдөлгөөнийг чанарыг нь дэмжсэн, насанд нь тохирсон дасгал, тоглоом, хэрэглэгдэхүүнийг ашиглан хүүхдийн сонирхлыг татах хэлбэрээр хөдөлгөөнийг дэмжсэн үйл ажиллагаа зохион байгуулахын тулд шаардлагатай хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангах хэрэгцээ байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Цэцэрлэгийн 2-5 настай хүүхдүүдийн хөгжих суралцах хэрэгцээг бүх талаар хангахын тулд хүүхэд хүсэл сонирхлоороо тоглох явцдаа суралцах чөлөөт үйлийг дэмжин, тоглонгоо мэдэрч, хүртэж хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэн цаашид хүүхэд бүрийн бие бялдрыг хөгжүүлж эрүүл мэндэд нь сайнаар нөлөөлөх зорилготой.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Даланзадгадын 25-р цэцэрлэгийн санаачилж аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дэмжсэн “Хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөрийн саналыг “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн ажлын албанд 2018 оны 1 дүгээр сарын 16 нд хүлээн авч сангийн санхүүжилтийн шаардлага журамд нийцэж байх тул Харилцааны хорооны хурлаар хэлэлцүүлэв.

Улмаар “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар уг төслийг хэлэлцэн Удирдах зөвлөлийн 06 тоот тогтоолоор уг төслийн саналыг санхүүжүүлэхээр дэмжиж төсөлд санал болгосон 20,000,000 төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв.

Захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зарласнаар “Эрхэт рай” ХХК шалгарч уг хөтөлбөрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, хөдөлгөөн эрүүл мэндийн төвийг тохижуулах ажлыг гүйцэтгэх гэрээг захиалагчтай байгуулав.

Захиалагч болон шалгарсан гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээг үндэслэн “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” уг байгууллагуудтай санхүүжилтийн гэрээ байгуулснаар хөтөлбөрийн үйл ажиллагаа эхлэв.

Гүйцэтгэгч “Эрхэт рай” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ашиглагч байгууллагад нийт 17 төрлийн 285 ширхэг тоглоом, техник хэрэгсэл, төхөөрөмжийг Захиалагч аймгийн ЗДТГ, орон нутгийн Өмчийн газар, ашиглагч байгууллагын төлөөллөөс бүрдсэн комисст хүлээлгэн өгөв.

Гэрээний дагуу уг тоног төхөөрөмж тоглоом хэрэгсэл нь гарал үүслийн гэрчилгээтэй, стандарт шаардлагыг бүрэн хангасан бөгөөд ийнхүү Даланзадгадын 25-р цэцэрлэг иж бүрэнхөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих төвтэй болж, хүүхдүүд сурч хүмүүжих нөхцөл сайжирч, хөтөлбөрийн төсөлд тусгагдсан зорилгыг бүрэн хангах орчин бүрдэв.

“УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧИН БЭЛТГЭХ” ХӨТӨЛБӨР



САНААЧЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“БАДРАНГУЙ-ОРШИХ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	192,600,000 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	183,900,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Политехник коллеж нь хүнд машин механизмын оператор, засвар ашиглалтын чиглэлээр сургалт явуулахдаа суурин жолоодлогын симулятораар ур чадвар эзэмшүүлэн төгсгөдөг. Суурин жолоодлогын симулятор нь орон зайн баримжаа олгох ажлын тоног төхөөрөмжийн гүйцэтгэх үүрэг нь ижил удирдлагын хэрэгслүүдийг ажиллуулах сайн талтай ч бодит экскаватор ажиллуулахад удирдлагын механизмууд нь зөрүүтэй байдаг. Ийм учраас ур чадвар олгох сургалтыг бодит экскаватор дээр явуулах нь илүү үр дүнтэй болно.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Өмнөговь Политехник коллежид дугуйт экскаватор болон хөдөлгүүр бусад эд ангиудаар сургалтын орчин бүрдүүлж суралцагчдын мэргэжлийн ур чадвар, ажлын байранд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Өмнөговь Политехник коллежийн санаачилсан энэхүү төслийн саналыг сангийн ажлын албанд хүлээн авч Харилцааны хорооны хурлаар хэлэлцүүлэн эрэмбэлүүлсний дагуу Сангийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн сургалт дадлагын зориулалтаар техник хэрэгсэл худалдан авч сургалтын орчин бүрдүүлэхэд чиглэсэн уг хөтөлбөрийг нийт 192,600,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэв.

Захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлаж “Политехник коллежид механизм, тоног төхөөрөмж, эд анги нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр “Бадрангуй орших” ХХК ийг сонгон гэрээ байгуулж, 2018 оны 8 дугаар сарын 27-ны өдөр өдөр сангийн ажлын албанд ирүүлэв.

2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь Захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Бадрангуй орших” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулав.

Гүйцэтгэгч “Бадрангуй орших” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу нийлүүлбэл зохих механизм болон бусад техник хэрэгслийг бүрэн нийлүүлж хүлээлгэн өгсөн тайланг захиалагч аймгийн ЗДТГ аас баталгаажуулснаар хөтөлбөр бүрэн хэрэгжив.

“ДОТУУР БАЙР-ХҮҮХДИЙН ЭЭЛТЭЙ ОРЧИН” ХӨТӨЛБӨР



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗАР**

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ВИШН МЕЖИК” ХХК, “ЭЛБЭГ ТУУЛАЙ” ХХК

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

114,049,483 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

110,183,448 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 17 дотуур байранд 868 хүүхэд амьдарч байна. Өргөн удам нутаг дэвсгэрт тархан суурьшсан нүүдлийн хэв маяг бүхий малчин өрхийн хүүхдүүдийг сурч боловсроход энэхүү дотуур байр чухал үүрэгтэй. Хүүхдүүд дотуур байранд жилийн 365 хоногийн 225-245-ийг өнгөрөөдөг. Нэн ялангуяа бага, дунд ангийн хүүхдүүдийн гэрээсээ удаан хугацаагаар хол амьдрах нь сэтгэл зүйн хувьд амаргүй даваа байдаг. Тэрхүү хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь дотуур байрны орчин нөхцөл чухал үүрэгтэй. Гэртээ байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхээр тав тухтай байлгахын тулд хичээллэх, тоглож нөхөрлөхөд нь шаардлагатай техник хэрэгсэл технологиор хангах зэрэг зүй ёсны шаардлага гарч ирдэг. Энэ асуудалд анхаарал хандуулж “Дотуур байр-хүүхдийн хөгжлийн орчин” үндэсний зөвлөгөөнийг 2017 онд зохион байгуулж уг зөвлөгөөнөөс ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг сайжруулах, хүүхдийн хөгжил, оролцоог хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах зөвлөмж гарч, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулах чиглэлээр 2018-2020 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө батлан гаргасан байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Дотуур байрны хүүхдүүдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх, сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжоор хангаж, найрсаг таатай уур амьсгал бүрдүүлнэ. Үүний тулд сургалтууд зохион байгуулж шаардлагатай компьютер техник хэрэгсэл, ширээ сандал, тавилга хэрэгслээр хангана.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Өмнөговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар төсөл санаачилж, захиалагч аймгийн ЗДТГ дэмжин “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-д ирүүлсэн.

Сангийн ажлын алба төслийн саналыг Харилцааны хороо, болон Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлснээр сангийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар тогтоолоор уг хөтөлбөрийг санхүүжүүлэхээр дэмжин батлав.

Захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж гүйцэтгэгчээр “Вишн межик” ХХК, “Элбэг туулай” ХХК -ийг сонгож гэрээ байгуулав. Захиалагч болон гүйцэтгэгч нарын гэрээг үндэслэн санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гэрээ байгуулснаар хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.

Гүйцэтгэгч компаниуд төслийн санал болон гэрээнд тусгагдсан компьютер, принтер, ширээ сандал, ус буцалгагч, хивсэнцэр, номын тавиур, оюуны сэтгэхүй хөгжүүлэх, оюуны тоглоомууд зурагт, тоон системийн хүлээн авагч зэрэг тоног төхөөрөмжийг нийлүүлэв.

Боловсрол соёл, урлагийн газар нь эд хогшил тоног төхөөрөмж хүлээлцэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулав.

Санаачлагч Боловсрол, соёл, урлагийн газар нь хөтөлбөрийн сургалтын бүхий л үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлж хөтөлбөрийн хүрээнд сургуулийн дотуур байрны багш, ажилчид болон хүүхдүүдийн дунд дараах сургалтууд зохион байгуулсан.

- “Чадварлаг тогооч”,
- “Дотуур байр хөгжлийн орчин”
- “Тулгамдсан асуудлаа хамтдаа шийдвэрлэе” сэдвээр багш ажилчдад зориулсан сургалт зохион байгуулсан бол хүүхдүүдэд зориулан:
- Компьютер, интернэтийн зөв хэрэглээ,
- “Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх”
- “Хүүхдийн эрх”
- “Сэтгэлийн хөдөлгөөн хянах стрессийг зохицуулах”
- Хүүхдүүдийн хоорондын харилцааг сайжруулахад туслах зохион байгуулав.

Ийнхүү говь нутгийн малчин түмний хүүхэд багачуулын хоёр дахь гэр болсон дотуур байрыг тохижуулах, аятай таатай нөхцөл бүрдүүлэх, хүүхдүүдэд болон тэдэнтэй ажилладаг багш, ажилчдад сургалт зохион байгуулсан хөтөлбөр амжилттай хэрэгжлээ.

“БАГШИЙН ХӨГЖИЛ-УР ЧАДВАР” ХӨТӨЛБӨР



САНААЧЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС
ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АЛТАНГАДАС НЭГДЭЛ-ӨМНӨГОВЬ” ТББ
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	158,915,000 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	158,915,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

2017 оны байдлаар Өмнөговь аймагт сургуулийн өмнөх боловсролын 28 байгууллагын 352 багш, 21 сургуулийн 11530 сурагчдад 742 багш хичээл зааж байна. Тус аймгийн нийт багш нарын 30 орчим хувь нь мэргэжлийн зэрэггүй байгаа юм. Тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийн 742 багш нараас тэргүүлэх, зөвлөх, заах аргач, ахлах мэргэжлийн зэрэгтэй багш нар 36 буюу 6 хувь байна. Энэ нь орон нутгийн төвөөс алслагдмал байдал, багш нар дахин суралцах санхүүгийн чадамжтай шууд хамааралтай бөгөөд багш нар өөрийн мэргэжлийн онцлог, үр өгөөжид эерэг хандлагатай болж, сургалтад тогтмол хамрагдан байнга ур чадвараа дээшлүүлэх боломж хязгаарлагдмал байдагтай холбоотой юм. Энэхүү хэрэгцээ шаардлагад үндэслэн сургалтыг орон нутагт зохион байгуулах шаардлагатай. Ингэснээр багшаа хөгжүүлж, боловсролын салбарт ахиц авчирна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төлөөлөл 160 багшид зориулан “Багшийн хөгжил-Ур чадвар” тусгай хөтөлбөр сургалт зохион байгуулах зорилготой.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Хоёрдахь жилдээ хэрэгжсэн энэхүү хөтөлбөрийн төслийг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс санаачлан боловсруулсан. Төслийн санал зохих журмын дагуу хэлэлцэгдэн “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны I улирлын хурлаар дэмжин санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Төсөл санаачлагч Өмнөговь аймгийн ЗДТГ болон захиалагч аймгийн Боловсрол соёл, урлагийн газар хөтөлбөрийн гүйцэтгэгчээр “Алтангадас нэгдэл-Өмнөговь” төрийн бус байгууллагыг сонгон гэрээ байгуулж ирүүлсэн тул захиалагч болон гүйцэтгэгч байгууллагуудтай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гэрээг 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулж хөтөлбөрийг эхлүүлэв.

Захиалагч байгууллагаас сонгон хамруулсан нийт багш нар:

- Багшийн хөгжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хяналт шинжилгээ үнэлгээ хийх, хөтөлбөр шинэчлэх
- Үндэсний хэл, соёл, ахуйн уламжлал, ёс заншлыг хүүхдэд эзэмшүүлэх, монгол хүний зан чанар, ёс зүйг төвөлшүүлэх
- Экологи, орчны эрүүл мэнд
- Эрүүл хооллолт, хүнсний аюулгүй байдал
- Хувь хүний манлайлал, багаар ажиллах чадвар, харилцааны урлаг
- Бизнесийн анхан шатны боловсрол зэрэг сэдвээр цогц сургалт зохион байгуулав.

Ийнхүү говь нутгийн хүүхэд багачуудад эрдэм ном заадаг багш нар маань сургалтад хамрагдаж мэргэжлийн ур чадвар, арга зүйгээ сайжруулж, туршлага солилцох боломж бүрдүүлсэн хөтөлбөр амжилттай хэрэгжлээ.

“ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН” ХӨТӨЛБӨР



Х.ШАРАВЫН НЭРЭМЖИТ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ

САНААЧЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ
ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АГЛУТ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	248,379,240 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	248,379,240 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын гавьяат эмч Х.Шаравын нэрэмжит Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь нийт 215 ортой, 200 гаруй ажиллагсадтай. Тус төвд жилдээ 8000 орчим хүн хэвтүүлэн эмчлүүлж, 50 мянга гаруй хүн осол гэмтлийн болон урьдчилан сэргийлэх үзлэгт ордог бөгөөд 1200 гаруй хүнд төрөл бүрийн мэс засал, ажилбар хийдэг.

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн түргэн тусламж, хүлээн авах яаралтай тусламж, эрчимт эмчилгээ сэхээн амьдруулах, гэмтэл, мэс засал, гемодиализ, мэдрэл, сэтгэц, уламжлалтын тасгууд, эхо, рентген кабинет, ариутгалын хэсэг байрладаг 50 ортой эмнэлгийг анхнаасаа үйлчлүүлэгчид болон багаж тоног төхөөрөмж зөөх зориулалтын цахилгаан шатгүй барьсан тул эмчлүүлэгчдийг өргөх, багаж төхөөрөмж зөөх зэрэгт хүндрэлтэй байдаг.

Ялангуяа өөрөө явж чадахгүй, мэс засалд орох шаардлагатай хүнд өвчтөнүүдийг энгийн шатаар зөөх нь үйлчлүүлэгчид, эмч сувилагч нарт ихээхэн хүндрэл учруулдаг. Энэ байдлыг засаж сайжруулахын тулд 50 ортой эмнэлгийг зориулалтын цахилгаан шаттай болгох шаардлага тулгарсан.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 50 ортой эмнэлэгт цахилгаан шат суурилуулж иргэд үйлчлүүлэгчид болон ажиллагсад ээлтэй орчин нөхцөл бүрдүүлж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Иргэдийн бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санаачилсан энэхүү төсөл Сангийн ажлын алба, Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр шат дараалан дэмжигдэж санхүүжилт нь Удирдах зөвлөлийн 2018 оны 06-р тогтоолоор батлагдсан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ХАМТРАН САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

-МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
-АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР,
-ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА,
-НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ХҮҮХДИЙН САН,
-НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН
АМЫН САН

НИЙТ ТӨСӨВ:

12,187,819,360 төгрөг

ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ:

4,268,657,180 төгрөг

НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:

2,993,414,100 төгрөг

НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:

778,774,400 төгрөг

ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ:

496,468,680 төгрөг

АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:

1,216,835,000 төгрөг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:

2,433,670,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймагт байнгын оршин суугч 60,675 хүний гуравны нэг нь 15 хүртэлх насны иргэд, гуравны хоёр нь 15-60 насны иргэд байна. 15-34 насны залуучууд нийт хүн амын 35%-ийг, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд мөн хүн амын гуравны нэгийг эзэлдэг. Хөдөлгөөнт хүн амын тоо их, оршин суугчидтайгаа бараг тэнцүү буюу ойролцоогоор 60,000 байгаа нь хүн амхурдацтай өсөхөд нөлөөлж байна.

Сүүлийн арваад жилд Монгол Улсын эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд сайжирч, сүрьеэ өвчлөлөөс бусад эрүүл мэндтэй холбоотой Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-уудад бүгдэд нь хүрсэн. Гэсэн хэдий ч ядуу, эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулахад бэрхшээл байсаар байна. Өмнөговь аймагт эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд 212.9, үр хөндөлт 1,000 амьд төрөлтөд 301 байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлт юм.

Өсвөр насны охидын төрөлт 2016 онд 1,000 амьд төрөлт тутамд 24 байсан. Тус аймагт халдварт болон халдварт бус өвчлөлийн аль аль нь өндөр байгаа юм. Умайн хүзүүний хорт хавдар нь эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолддог хоёр дахь хавдар юм. Умайн хүзүүний хорт хавдрын үзлэг, оношилгоо Өмнөговь аймагт доогуур үзүүлэлттэй буюу оршин суугчдын ойролцоогоор 30 хувийг хамарч байна. Улсын хэмжээнд түгээмэл тохиолддог жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) зэрэг нь уул уурхайн үйл ажиллагааны оргил үед хамгийн өндөр байдаг бөгөөд энд өргөн тархсан. Нийгэм, эдийн засгийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хэрэгжилт эхний үе шатандаа явж байгаа бөгөөд орон нутгийн чадавхыг хөгжүүлэх, орон нутгийн түвшин дэх хөрөнгө нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх хэрэгцээ их байна.

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудыг дэмжих НҮБ-ын бүтэц дэх байгууллагуудын нэгдсэн хөтөлбөр нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт 2030, Өмнөговь аймгийн хөгжлийн стратеги, түүнчлэн НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ)-ний Үр дүн 2 (нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хүртээмжтэй нийгмийн үйлчилгээг хүргэх) болон Үр дүн 3-ыг (иргэдийн дуу хоолойг дэмжих, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх) хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээний хувь гэр бүлтэй эмэгтэйчүүдийн дунд 2003 онд 69% байсан бол 2013 онд 54.6% болж буурсан. Үүнтэй адилаар, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ 2003 онд 4.6% байснаа 2013 онд 16% болж нэмэгдсэн ба 15-19 насны эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (36.4%) байна. Үр хөндөлтийн түвшин 2008 онд 1,000 амьд төрөлтөд 169 байснаа эрс өсөж 2013 онд 205 болсон нь санаа зовоож байгаа юм. Өөр нэг санаа зовоож буй асуудал бол тэмбүүгийн өвчлөл 15-24 насныхны дунд 10,000 хүн тутамд 60.4, 25-49 насныхны дунд 10,000 хүн тутам 32 байгаа явдал юм.

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, өсвөр насныхан, залуучуудын эрүүл мэндийн асуудал ихээхэн анхаарал татаж байгаа юм. 2016 онд эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөнд 212.9, ба үр хөндөлт 1,000 амьд төрөлтөнд 301 байсан нь улсын дунджаас хамаагүй өндөр үзүүлэлт юм. Энэ байдал онц өөрчлөгдөлгүй удсан. Жишвээс 2016 онд улсын хэмжээнд эхийн эндэгдэл (MMR) 100,000 амьд төрөлтөд 48 байв. Өмнөговь аймгийн хэмжээнд өсвөр насны охидын төрөлт 1,000 амьд төрөлтөд 24 байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд:

1. Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.
2. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.
3. Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэлт, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.
4. Орон нутгийн түвшний засаглал бэхжиж, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт өсөж, иргэдэд илүү сайн хүрч ажилласан.
5. Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлжиж, залуучуудын асуудлаарх бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.
6. Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Говийн оюу ХДС, НҮБ-ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, Австралийн Засгийн газар, Монголын Засгийн газар 12,1 тэрбум төгрөгийн хамтарсан санхүүжилт хийж байна
- 6 зорилтын хүрээнд Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Үр дүн 1: Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.
- Үр дүн 2: Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.
- Үр дүн 3: Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.
- Үр дүн 4: Орон нутгийн түвшний засаглал бэхжиж, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт бий болгох, хүрч үйлчлэх ажил хийгдсэн байна.
- Үр дүн 5: Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлжиж, залуучуудын асуудлаарх бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.
- Үр дүн 6: Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Үр дүн 1:

- БОЭТ, ЭМГ-ын удирдлага, эх баригчид, эмэгтэйчүүдийн эмч нарын чадавхийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр бэхжүүлэх чиглэлийн сургалт зохион байгуулсан

- Аймгийн ЗДТГ-тай хамтран ажиллаж шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах захиалга хийсэн
- Ханбогд суманд сургалт явуулсан. Ханбогд, Даланзадгад, Цогтцэций сумдын эмнэлэгт өсвөр үеийн кабинетуудыг тохижуулах
- Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдад өргөжүүлж сүлжээгээр холбогдоход шаардлагатай тоног төхөөрөмж захиалга хийсэн

Үр дүн 2:

- БЗДХ-тай 1120 өвчтөнийг эмчлэх эм худалдан авах захиалга хийсэн
- БЗДХ-ын урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэгийн аргачлал боловсруулах ажлыг БОЭТ, ЭМГ-тай хамтран хийсэн

Үр дүн 3:

- ЭМАШТҮ-нд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь төслийн санал Австралийн засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар болж 27000 Австрали долларийн дэмжлэг авсан ба явуулын эрүүл мэндийн технологи, нэн шаардлагатай тоног төхөөрөмжинд зарцуулагдана

Үр дүн 4:

- Хүүхдэд ээлтэй орон нутаг хэлэлцүүлгийг удирдлагын багийн дунд зохион байгуулсан
- БОЭТ-ийн төрөх тасгийн амбулаторын хэсгийг тохжуулах засварын ажил хийнэ

Үр дүн 5:

- Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумдуудад байгуулагдаж анхдугаар хуралдаан зохион байгуулагдсан

Үр дүн 6:

- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээг байгуулахаар орон нутгийн зүгээс 175 сая төгрөгийг төсөвт суулгасан

2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР:

ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ ХӨТӨЛБӨР



САНААЧЛАГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗАР**

ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ЗАГИЙН ХУДАГ” ХХК, “БОЛОР УС” ХХК

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

400,000,000 төгрөг

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

386,890,968 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдад бэлчээрийн худаг, уст цэг дутагдалтай шалтгаанаар ашиглагдахгүй байгаа бэлчээрийн эдэлбэр газар харьцангуй их байна. Нийт малын тоо толгой, нэг малчин өрхөд ногдох малын тоо толгой жил тутам өсөн нэмэгдэж байгаа одоогийн нөхцөлд бэлчээрийг усжуулах, газрын доорхи уст цэгийг хайгуул судалгааны аргаар олж тогтоох, эвдэрч гэмтсэн худгуудыг сэргээн засварлах зэргээр бэлчээрийн ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сайжруулах нэн шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын нутгийн иргэдийн ундны усны нөхцлийг сайжруулах, нутгийн 10-12 өрхийн 8000-10,000 мал сүргийн бэлчээрийн усан хангамжын хүртээмж дээшлүүлэх, бэлчээрийн ашиглалт сайжирч даац хэтрэлт, талхлагдалт багасгана

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Энэхүү Чандмань эрдэнэ төслийн хүрээнд зүүн бүсийн Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын 7 багийн 10500 га орчим бэлчээрийг хамарсан усан хангамжийн дутагдалтай, уст цэгээс алслагдсан бэлчээрийн нутагт:

- 4 ширхэг инженерийн хийцтэй худгийг сэргээн засварлах, ан амьтанд зориулсан нарны энергээр ажиллах 3 ширхэг худгийг шинээр гаргана
- 20 ширхэг энгийн хийцтэй худаг шинээр гаргах, 40 ширхэг бага гүнтэй худаг сэргээн засварлана.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

“Болорус” ХХК нь Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумд болох Баян-Овоо, Манлай, Ханбогд сумдын нутагт ан амьтанд зориулсан инженерийн хийцтэй 3 ширхэг худаг шинээр гаргах, мөн Баян-Овоо, Манлай, Ханбогд, Цогт-Овоо сумдын нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй 4 ширхэг худгийг сэргээн засварлаж ашиглалтанд шилжүүлж байна.

“Загийн худаг” ХХК нь Ханбогд, Баян-Овоо, Манлай, Цогт-Овоо сумдын нутагт тус бүр 5 ширхэг буюу нийт 20 ширхэг энгийн худаг шинээр гаргах, мөн тус сумдын нутагт тус бүр 10 ширхэг буюу нийт 40 ширхэг худаг сэргээн засварлаж ашиглалтанд шилжүүлж байна.

2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОРОН НУТГИЙН БИЗНЕС ХӨГЖИЛ ЧИГЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР:

“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:	GERMANY ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ, ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ
НИЙТ ТӨСӨВ:	5,354,074,000 төгрөг
ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ:	2,677,037,000 төгрөг
GERMANY ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГИЙН САНХҮҮЖИЛТ:	1,946,936,000 төгрөг
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН САНХҮҮЖИЛТ:	730,101,000 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	900,000 EBPO

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

2017 онд “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”, IRIM судалгааны хүрээлэнтэй хамтран Өмнөговь аймгийн иргэд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр олон талт хэлэлцүүлгийг зохион байгуулж “Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн 2018-2021 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг боловсруулан сангийн Харилцааны хороо, Удирдах зөвлөлийн хурлуудад танилцуулан батлуулсан. Дээрх үндсэн чиглэлд тусгагдсан “Орон нутгийн жижиг, дунд бизнесийн хөгжил олон талт хэлэлцүүлэг”-ийн тайланд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймаг, Говийн бүсэд нийгмийн хөгжил, эдийн засгийн төрөлжилт, өсөлтийг урт хугацаанд хангах
- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох
- Орон нутаг, бүс, үндэстний түвшинд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх Орон нутгийн хөгжлийн урт хугацааны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо, чадавх, өрсөлдөх чадварыг сайжруулах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Олон улсын санхүүгийн корпорацийн хамтарсан санхүүжилтээр Даланзадгад суманд “Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх” хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд:

- Даланзадгад сумын төвд байгуулах Бизнесийн инноваци хөгжлийн төвийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, менежментийн тогтолцоо зэргийг тодорхойлон төвийг төрийн бус байгууллага байхаар холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үүсгэн байгуулна
- АЗДТГ, “Оюу Толгой” ХХК, хөтөлбөрийн хамтран санхүүжүүлэгч байгууллагуудын төлөөлөл, бие даасан эдийн засагч нарыг оролцуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл төвийн үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ
- Төвийн үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч GIZ /Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/-с удирдан хэрэгжүүлнэ
- Төвөөс үйлчилгээ авахаар бүртгүүлсэн компаниудад урьдчилсан үнэлгээ, дүн шинжилгээ хийж түвшнийг нь тогтоох бөгөөд компанийн удирдлагатай санал солилцон тохирох чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулна
- Чадавхжуулах сургалтууд нь төлбөртэй, 1-3 хоног үргэлжлэх бөгөөд дараах сэдвүүдээр зохион байгуулагдана. Үүнд:
 - Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал
 - Бизнесийн нэгдмэл байдал ба дүрэм журмыг мөрдөх нь
 - Санхүүгийн боловсрол
 - Хүний нөөцийн удирдлага
 - Компанийн удирдлага менежмент
 - Худалдан авалт, ложистик, нийлүүлэлтийн сүлжээний менежмент, кластерын хөгжил
 - Чанарын удирдлага
 - Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийн менежмент, аж үйлдвэр
 - Хууль эрх зүй, гэрээний менежмент
 - Дижитал технологи ба хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах
 - Борлуулалт, маркетинг
 - Инновацийн менежмент
 - Байгаль орчин тогтвортой байдал

- Сургалтуудыг дараах техник үйл ажиллагаануудтай хослуулж зохион байгуулна.
Үүнд:
 - Түншлэл тогтоох: Аж үйлдвэрийн үзэсгэлэн худалдаа, аялал, таницлах аялал, ажлын байран дээрх сургалт
 - Худалдан авагч, борлуулагчийн хооронд уулзалт, семинар зохион байгуулах
 - Онлайнаар бизнесийг холбох платформ, вэбсайт, мэдээллийн бааз байгуулж түүнд бизнесийн түнш хайж байгаа эсвэл туслан гүйцэтгэгч компаниуд бүртгүүлж болох
 - Кластерын хөгжил /Кластер болон салбарын түвшинд уулзалт зохион байгуулах/
- Аймгийн ЭДТГ-т эдийн засгийн бодлого, зохицуулалтыг сайжруулахад ялангуяа жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлнэ

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Оюу толгой ХХК-ийн одоогийн ханган нийлүүлэгч, ханган нийлүүлэх болохоор ажиллаж байгаа компаниудад ЖДҮ-үүдийг сургаж, чадавхыг хөгжүүлэх бөгөөд үүний үр дүнд тухайн компанийг гүйцэтгэл, үйл ажиллагаа сайжирна
- Өмнөговь аймаг цаашлаад улс даяарх ЖДҮ-үүд эхлээд орон нутагтаа дараа нь бүс, үндэсний түвшинд улмаар олон улсын түвшинд хүрч ажиллах чадавх аажмаар нэмэгдэнэ
- Төсөлд хамрагдсан ЖДҮ-үүд уул уурхайн бусад компанийн ханган нийлүүлэгч болох боломж нэмэгдэнэ

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Даланзадгад сумын бизнес хөгжлийн төвийн үйл ажиллагааг явуулах байр түрээслэсэн.
- 2018 оны 10-12 дугаар саруудад 3 төрлийн сургалт (Хүний нөөц, бизнесийн ёс зүй, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, Менежментийн үндэс, Санхүү нягтлан бодох бүртгэл, Худалдаа маркетинг, харилцаа холбоо) чиглэлээр 16 удаагийн сургалт явуулж 42 аж ахуй нэгжийн 115 ажилчин хамрагдсан.
- Говь Фестивал 2018 үйл ажиллагааны үеэр Бизнес хөгжлийн төвийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаар танилцуулга хийсэн
- Ханбогд, Даланзадгад, Манлай, Цогтцэций сумдад танилцуулга хийсэн
- 18 сургалт 7 модуль боловсруулан туршсан. 3 нэмэлт сургалтын модуль 12 нэмэлт сургалтын хөтөлбөр боловсруулсан
- 20 хувь хүн, байгууллага сонгож сан бүрдүүлсэн.
- Сургалт явуулж 6,480,000 төгрөг цугларсан бөгөөд Бизнес инноваци хөгжлийн данс нээж төвлөрүүлсэн. Уг мөнгийг хэрхэн зарцуулах шийдвэрийг төслийн Удирдах хорооноос гаргана.

ЗОРИЛТОТ СУМДАЙ БАЙГУУЛСАН КВОТЫН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ

КВОТЫН САНХҮҮЖИЛТ, ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд олгох жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Түншлэгч болон уул уурхайгүй сумдад (хамтад нь “Зорилтот сумд” гэх) квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын болон Өмнөговь аймгийн нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, тусгай дэмжлэг шаардлагатай хүмүүсийн амьдрал ахуй, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилахыг эрмэлзэнэ.



Тухайн жилд Түншлэгч болон уул уурхайгүй сумдад дээрх зорилгоор хуваарилах санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тогтооно:

- Ханбогд сум 70,000 ам.доллартай тэнцэх төгрөг
- Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд 50,000 ам.доллартай тэнцэх төгрөг
- Уул уурхайгүй сумд тус бүр 30,000 ам.доллартай тэнцэх төгрөг.

№	Зорилтот сумын нэр	2018 онд хуваарилагдсан санхүүжилт	Зарцуулсан санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	Ханбогд сум	170,356,900	169,862,754	494,146
2	Манлай	121,683,500	121,344,335	339,165
3	Баян-Овоо	121,683,500	95,320,675	26,362,825
4	Даланзадгад	121,683,500	53,300,000	68,383,500
5	Баяндалай	73,010,100	73,010,100	-
6	Сэврэй	73,010,100	73,001,500	8,600
7	Булган	73,010,100	65,318,689	7,691,411
8	Номгон	73,010,100	72,992,500	17,600
9	Цогт-Овоо	73,010,100	47,794,590	25,215,510
Нийт		900,457,900	771,945,143	128,512,757

2018 ОНД ХАНБОГД СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

“ХАНБОГД СУМЫН ҮЛЭМЖИЙН ЧАНАР СОЁЛЫН ТӨВД МОДОН ЭДЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

ИРГЭН Х.ЛХАГВАСҮРЭН

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

9,972,995 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Шинээр ашиглалтанд орсон “Үлэмжийн чанар” соёлын төв ард иргэдэд тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс эдэлгээтэй сайтай тавилга шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын соёл урлагийн үйл ажиллагааг зохион байгуулахад таатай орчин бүрдүүлэн зохион байгуулж байгууллагын өнгө үзэмжийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Ханбогд сумын Үлэмжийн чанар соёлын төвд 11 нэр төрлийн 17 ширхэг модон тавилга, хэрэгслийг үйлдвэрлэн нийлүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Ханбогд сумын соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, иргэд ая тухтай орчинд соёлын үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Ханбогд сумын үлэмжийн чанар соёлын төвд модон эдлэл нийлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Х.Лхагвасүрэнтий санхүүжилтийн гэрээ байгуулав
- Ханбогд сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Хэрэгжүүлэгч иргэн Х.Лхагвасүрэн хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, иргэд ая тухтай орчинд соёлын үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ.

“ХАНБОГД СУМЫН ҮЛЭМЖИЙН ЧАНАР СОЁЛЫН ТӨВД ХӨГЖИМ, ГЭРЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ИРГЭН Н.БАТТУЛГА
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	9,961,700 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Шинээр ашиглалтанд орсон “Үлэмжийн чанар” соёлын төвд ард иргэдэд тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс хөгжим, тайзны гэрэлтүүлэг суурилуулах нэн шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын соёл урлагийн үйл ажиллагааг зохион байгуулахад таатай орчин бүрдүүлэн зохион байгуулахад шаардлагатай хөгжим, гэрэлтүүлгийг нийлүүлэн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Ханбогд сумын “Үлэмжийн чанар” соёлын төвд 8 нэр төрлийн 15 ширхэг хөгжим, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж нийлүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Ханбогд сумын соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, иргэд ая тухтай орчинд соёлын үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан, Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Ханбогд сумын үлэмжийн чанар соёлын төвд хөгжим, гэрлийн тоног төхөөрөмж нийлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Н.Баттулгатай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Ханбогд сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Хэрэгжүүлэгч иргэн Н.Баттулга хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, иргэд ая тухтай орчинд соёлын үйлчилгээгээр хангагдах нөхцөл бүрдэнэ.

“БИЗНЕС ХӨТӨЧ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ХАНБОГД ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ” ТББ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	35,000,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сум уул уурхай, хил гааль түшиглэсэн томоохон суурин газар болон өргөжиж хүн амын төвлөрөл ихэссэнийг дагаад бизнес эрхлэх таатай орчин, нөхцөл бүрдсэн. Одоогийн байдлаар тус суманд бүртгэлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани-356, хоршоо-11, төсөвт байгууллага-14, ОНӨААТҮГ-3, төрийн бус байгууллага-16, ЗБН-1 нийт 401 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээрийн удирдах ажилтнуудад эдийн засаг, санхүүгийн талаар мэдлэг мэдээлэл өгөх, дэмжин туслах, чадавхжуулах шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад бизнесээ удирдан зохион байгуулах, төсөв, санхүүгийн талаарх мэдлэгээ сайжруулах, бизнесээ өргөжүүлэх, үр ашигтай ажиллахад нь дэмжлэг болох

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

6 удаагийн сургалтанд нийт 200 хүн хамрагдаж, худалдан авах ажиллагааны АЗ сертификат-30 хүнд, няравын үнэмлэх-20 хүнд шалгалтын дүнгээр олгоно

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Хөтөлбөрт хамрагдсан иргэд, аж ахуй нэгж байгууллага нь бизнесээ удирдан зохион байгуулахад төсөв санхүүгийн талаар мэдлэгтэй болж, бизнесээ өргөжүүлэх, үр ашигтай ажиллахад дэмжлэг болно, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хэрэгжилтийг ханган тендерийн үнэлгээний хороонд орох боломжтой гишүүдийн тоог нэмэгдүүлэх, мөн цаашлаад суманд санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бие даасан нэгжтэй болох юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Бизнес хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Ханбогд хөгжлийн төлөө”ТББ-тай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Хэрэгжүүлэгч “Ханбогд хөгжлийн төлөө”ТББ хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэд, аж ахуй нэгж байгууллага нь бизнесээ удирдан зохион байгуулах төсөв санхүүгийн талаар мэдлэгтэй болж, бизнесээ өргөжүүлэх, үр ашигтай ажиллахад дэмжлэг болно. Түүнчлэн ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хэрэгжилтийг ханган тендерийн үнэлгээний хороонд орох боломжтой гишүүдийн тоог нэмэгдүүлэх, мөн цаашлаад суманд санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бие даасан нэгжтэй болох юм.

“ЧАДВАРЛАГ СУРАГЧААС ОЮУНЛАГ ИРГЭН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ОЮУНЫ-ӨРГӨӨ ХАНБОГД” ТББ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

17,410,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, өөрийгөө зөв илэрхийлж сурах, нийгэмд эзлэх тодорхой байр суурьтай хүн болж төлөвшихөд нь туслах үүднээс хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар илтгэл, эсээ бичих, аливаа сэдвийн хүрээнд судалгаа хийж үр дүнг нь боловсруулах, бусдад танилцуулах, хэлэлцүүлэх, мэтгэлцэх зэргээр чадавхжуулах шаардлагатай байдаг.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрт хамрагдсан ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, өөрийгөө зөв илэрхийлж сурах, нийгэмд эзлэх тодорхой байр суурьтай хүн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Ханбогд сумын ЕБС-ийн 9-11-р ангийн 7 бүлгийн 210 сурагчийг 3 сарын хугацаанд илтгэх мэтгэлцэх, өөрийгөө тодорхой илэрхийлэх чадварт сургана.
- Сургалттай холбоотой үйл ажиллагаануудыг зохион байгуулна. (илтгэлийн болон эсээ бичлэгийн уралдаан, хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх)
- Сурагчдын чадавх оролцооны судалгааг хийнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Ханбогд сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад ярих, илтгэх, тодорхой сэдвээр илтгэл эсээ бичих дадал чадвар олгох, мөн сурагчдын багаар ажиллах, бие биеэсээ суралцах боломжийг нэмэгдүүлэх, тэднийг санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, соёлтойгоор мэтгэлцэж сурах, бусдыг сонсох чадварт сургана. Мөн тус сумын сургуулийн хэмжээний нийт ахлах ангийн сурагчдыг тодорхой боловсруулсан хөтөлбөр бүхий сургалтаар дээрх чадваруудыг эзэмшүүлж ярих, бичих, мэтгэлцэх чадварт үе шаттайгаар суралцуулж хөгжүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Чадварлаг сурагчаас оюунлаг иргэн” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Оюуны-Өргөө Ханбогд”ТББ-тай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Хэрэгжүүлэгч “Оюуны-Өргөө Ханбогд” ТББ хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЕБС-ийн 9-11-р ангийн 7 бүлгийн 210 сурагчдын илтгэх, үзэл бодлоо зөв нээлттэй илэрхийлэх, багаар ажиллах чадварууд дээшилсэн

“ЖАРГАЛТАЙ ХҮҮХДҮҮД” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

ХАНБОГД СУМЫН 21-Р ЦЭЦЭРЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

14,488,214 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сум нь уул, уурхай, хил гааль, нүүрсний тээвэрлэлтийг түшиглэсэн томоохон төв суурин газар тул хүн ам олноор шилжин ирж суурьшаар сумын хүн ам 10,000 гаруй болсон байна. Үүнээс шалтгаалан сургуулийн өмнөх насны хүүхдийн тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж цэцэрлэгийн анги дүүргэлт жил бүр хэтэрдэг. Иймд бага насны хүүхдийг сурч боловсроход нь аюулгүй, тохилог орчинг бүрдүүлэх нэн шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Ханбогд сумын 21-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын дээврийг шинэчилж, вакуум цонх суурилуулан 2 анги шинээр нэмэгдүүлэн засварлах.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Вакуум цонх суурилуулах ажил
- 2 ангийн модон шалыг пракетаар солих
- 2 ангийн дээврийг засах

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- 3-5 ажлын байр шинээр нэмэгдэнэ
- Багш, хүүхдүүд тохилог орчинд ажиллаж, сурах орчин бүрдэнэ
- Сургалтын өмнөх боловсролын чанар, хүртээмж сайжирна

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Жаргалтай хүүхдүүд” төслийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч Ханбогд сумын 21-р цэцэрлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Ханбогд сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Төслийн гүйцэтгэгч Ханбогд сумын 21-р цэцэрлэг гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын 21-р цэцэрлэгт шинээр 3-5 ажлын байр бий болж багш, хүүхдүүд тохилог орчинд ажиллаж, сурах орчин бүрдэн сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмж сайжирсан.

“СЭТГЭМЖ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

ИРГЭН Б.ТӨМӨРБААТАР

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

25,000,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сурагчдын оюуны спортоор хичээллэх сонирхлыг өдөөж, тэднийг аймаг, улс, тив, дэлхийн хэмжээний тэмцээнүүдэд оролцох боломжоор хангах, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэхэд урт хугацааны зохион байгуулалттай арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуульд даамны дугуйлан хичээллүүлэхэд шаардлагатай сандал, ширээ, техник хэрэгсэл, даам, бусад хичээлийн хэрэгслээр хангагдсан тохилог клубтэй болж, 1-9 дүгээр ангийн 840 сурагчид даамны спортоор хичлээллэн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, сэтгэн бодох чадвараа хөгжүүлэх, аливаа зүйлд хүлээцтэй хандах, зөв дүгнэлт шийдвэр гаргах зэрэг чадварыг төлөвшүүлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн 1 өрөөг тохижуулан даамны клуб нээж 1-9 дүгээр ангийн 840 сурагчдад 9 сарын хугацаанд 100 буудалт болон 64 буудалт даамны 640 цагийн сургалт зохион байгуулах,
- Улаанбаатар хотод болох улсын чанартай тэмцээнд баг бэлтгэн 2 удаа оролцуулах.
- Улаанбаатар хотоос сургагч багш урьж тэмцээнд оролцох сурагчдад 10 өдрийн сургалт зохион байгуулна

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Сурагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, сэтгэн бодох чадвараа хөгжүүлэх, аливаа зүйлд хүлээцтэй хандах, зөв дүгнэлт шийдвэрийг гаргах зэрэг чадваруудыг төлөвшүүлэх эерэг үр дүн гарах юм.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Сэтгэмж” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Б.Төмөрбаатартай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Б.Төмөрбаатар гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын сурагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газартай болов.

“ЗАЛУУСЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ХАНБОГД ЗАЛУУСЫН НЭГДЭЛ” ТББ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

10,512,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Залуучуудыг хөгжүүлэх төрийн бодлого болон уул уурхай түшиглэсэн сумын онцлогтой уялдуулан орон нутгийнхаа залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах, зөв дадал хэвшилд төлөвшүүлэх шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын залуучуудыг уул уурхайн компанид ажиллахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор англи хэлний мэдлэгийг нь сайжруулах, хүнд машин механизмын мэргэжлийн үнэмлэхтэй сургалтан хамруулах, чадавхжуулах
- Оюу толгойн уурхайн цогцолбороос Ханбогд сумын төв хүртэлх авто замын дагуух нөлөөллийн бүсийн иргэд, мал сүргийн эрүүл мэнд, амь насыг авто замаас үүсэх осол, аюулаас хамгаалах

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- FARO сургалтын төвөөс 5 хоногт 600 үйл үг цээжлүүлэх англи хэлний сургалт зохион байгуулах
- Хөгжлийн шийдэл ТББ-аас гарааны бизнесийг дэмжих 2 хоногийн сургалт, гарааны бизнесийн дадал олгон хэвшүүлэх хөтөлбөр
- Форум ланд сургалтын төвөөс 15-20 иргэдэд хөнгөлөлттэй үнээр уул уурхайн хүнд машин механизмын операторын 4-5 чиглэлээр мэргэжлийн үнэмлэхтэй сургалт, практик дадлага хөтөлбөр

- Оюу толгойн уурхайгаас Ханбогд сумын төв хүртэлх авто замын дагуух 5-8 өрхийн иргэдэд зориулан авто замын осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар нөлөөллийн ажил зохион байгуулна

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Зорилтот бүлгийн залуус чадавхжиж, малчин иргэд авто замын осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэлтэй болсон байна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн 2018-03-15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Залуусын оролцоог нэмэгдүүлэх нь” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- Говийн оюу хөгжлийг дэмжих сан нь захиалагч Ханбогд ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч Ханбогд залуусын нэгдэл ТББ-тай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч Ханбогд залуусын нэгдэл ТББ гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын зорилтот бүлгийн залуус чадавхжиж, малчин иргэд авто замын осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэлтэй болсон байна.

“ДЕКУПАЖ ГАР УРЛАЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЭНХ ЭНГҮҮН ХАТАД” ТББ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	3,000,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ажил орлогогүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хямд өртөгтэй материалаар, гэртээ үйлдвэрлэл явуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд декупаж урлалыг тохиромжтой гэж үзэн хөтөлбөрийн саналыг боловсруулсан бөгөөд Ханбогд суманд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байдаггүй тул орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломжтой юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын хөдөлмөр эрхэлдэггүй, хөгжлийн бэрхшээлтэй 10 эмэгтэйг 10 хоногийн декупаж урлалын сургалтад хамруулна.
- Сургалтад хамрагдсан хүмүүст батламж гардуулах
- Сургалтаар хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргах

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Ханбогд сумын хөдөлмөр эрхэлдэггүй, хөгжлийн бэрхшээлтэй 10 эмэгтэйд 10 хоногийн хугацаанд декупаж урлалын чиглэлээр сургалт хийнэ

- Сургалтад хамрагдсан хүмүүст батламж гардуулах
- Сургалтаар хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргах

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Зорилтот бүлгийн иргэд ерхийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Декупаж гар урлал” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч Энх энгүүн хатад ТББ-тай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Энх энгүүн хатад ТББ хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын ажил эрхэлдэггүй, орлогогүй, хөгжлийн бэрхшээлтэй 10 эмэгтэй хаягдал цаас, сонин болон хямд өртөгтэй материалаар гар урлалын бүтээлүүд хийж сурах бөгөөд цаашлаад тэд өөрийн бичил бизнестэй болох боломж бүрдэх юм.

2018 ОНД МАНЛАЙ СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

“НОМ БОЛ ЕРТӨНЦИЙГ ХАРАХ ЦОНХ МӨН” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЕБС-ИЙН БАГШ НАРЫН БҮЛЭГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	18,992,168 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Манлай сумын ерөнхий боловсролын сургуулийн нийт сурагчдаас завсарлагааны цаг болон чөлөөт цагийг хэрхэн өнгөрүүлдэг вэ гэсэн санал асуулга авахад 41.1% нь утсаар тоглодог, 22.6% нь фэйсбүүк болон интернэт хэрэглэдэг 21% нь хичээлээ давтдаг, 2% нь ном уншдаг гэсэн судалгаа гарсан тул үүнээс үндэслэн анги бүрд номын сан байрлуулж, сурагчдыг номтой нөхөрлүүлэх шаардлагатай болсон. Мөн үүнтэй холбоотой “Номын жагсаалт шинэчлэн батлах тухай” БСШУ-ны сайдын 2011 оны 228 дугаар тушаалын хавсралтыг үндэслэв.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ухаалаг утасны хэрэглээг хэтрүүлэхээс сэргийлж, завсарлагааны цагийг номтой нөхөрлөж өнгөрүүлэх,

- Суралцагчдыг номтой нөхөрлүүлж, ангийн номын сангийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- “Номын богц”-ыг сурагчдаар дамжуулан аялуулж гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Анги бүрийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон заавал уншиж судлах номыг худалдан авна.
- Анги бүрд үзэмж сайтай, орчин үеийн, эрүүл ахуйн шаардлага хангасан номын тавиурыг сонгон авна.
- Номын тавиурыг байрлуулж, номыг төрөлжүүлж, ангийн номын сандаа бүртгэнэ.
- Сурагчдаар уншсан номын тэмдэглэл хөтлүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Анги бүрийг нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном, номын тавиуртай болгоно.
- Номын сангаар дамжуулан сурагчдын унших, бичих, ярих, зохион найруулан бичих чадвар сайжирна.
- Гэр бүлд “Номын богц”-ыг аялуулна.
- Номын санг бага, дунд боловсролын заавал унших номоор баяжуулна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг Аз хур номын дэлгүүрээс заавал унших номын жагсаалтад багтсан номуудыг авсан.
- Анги бүрд тохирсон номын тавиурыг хийлгэж байрлуулсан.
- Сурагчдын номын сангийн карт хөтлөн, уншсан номын хөтөлгөө хийж байгаа,
- Гэрээр аялах богцоор дамжуулан сурагчдын гэр бүлээрээ уншсан номын хөтөлгөө, тэмдэглэл хөтлүүлж байгаа.

ХАЛУУН УС ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	С.ТҮВШИН-АЛДАР
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	29,890,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сум нь 2580 хүн амтай ба жилдээ явуулын 1,000 гаран хүн уг сумаар дайран өнгөрдөг. Сумын нийтийн халуун усны барилга хуучирч, нуралт үүссэн ба одоо уг барилгын суурин дээр шинэ тамгын газрын барилга баригдахаар шийдвэр гарснаар суманд шинээр халуун усны газартай болох зайлшгүй шаардлага үүсээд байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэдийн хэрэгцээг хангасан халуун усны газартай болж, сумын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж тогтвортой, найдвартай үйл ажиллагаа бүхий халуун усны газартай болох.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сумын төвийн ахуйн үйлчилгээний төвийн барилгыг халуун усны зориулалттай болгож өөрчилж, халуун усны газар байгуулна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сум нийтийн халуун усны газартай болсноор малчид, иргэд, явуулын иргэдийн халуун усанд орж хувийн ариун цэвэр сахих хэрэгцээ хангагдана. /жилд дунджаар 20,000 хүн үйлчлүүлдэг/
- Халуун ус ажиллуулах нэг хүний ажлын байр бий болно.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Сумын төвийн ахуйн үйлчилгээний барилгын 2 өрөөг халуун усны зориулалттай болгон засварлаж халуун усны газар байгуулсан. Сумын суурин иргэд болон явуулын хүмүүс халуун усны газраар тогтмол үйлчлүүлж байна.
- Иргэдийн хүсэлт, хэрэгцээ шаардалагад тулгуурлан шинээр халуун уурын өрөөг тохижуулахаар ажиллаж байна.

ЗӨВ ДАДАЛ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"ЭРҮҮЛ НАСЖИЛТ" ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	2,468,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын хэмжээнд цусны даралт ихсэх өвчтэй хүмүүс цөөнгүй байна. Тэд эмээ тогтмол хэрэглэж хэвшээгүйгээс цус харвах, амь насаа алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол их байна. Түүнчлэн суурь өвчин, сульдаа, оюуны болон өсөлтийн хоцрогдолтой хүүхдүүд ханиад томуугаар илүү өвчилж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын эрсдэлтэй бүлгийн иргэдийн нас болон биеийн байдалд нь тохирсон дасгал сургуулилтыг зааж, мэдээлэл өгөх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Эрүүл мэндийн төвийн хяналтад байгаа даралт ихсэх өвчтэй хүмүүст даралтаа хэрхэн хянах, хэмжих талаар сургалт явуулна.

- Ахмад настуудын дунд “Зөв хооллолт, дасгал хөдөлгөөн”-ий талаар сургалт явуулж дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлнэ,
- 0-6 сартай хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн асаргаа, чийрэгжүүлэлтийн талаар сургалт явуулна

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Цусны даралт ихтэй хүмүүс өөрийнхөө даралтыг хянаж чаддаг, даралтын эмээ тогтмол ууж, зөв хооллох, дасгал хөдөлгөөн хийж сурснаар цус харвах, зүрхний шигдээс зэрэг өвчнөөс сэргийлэх болно.
- Хүүхдийг зөв асарч, чийрэгжүүлснээр ханиад томуу, бусад суурь өвчнөөс сэргийлнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Судалгааны дагуу эрсдэлтэй бүлгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол үзүүлж, чийрэгжүүлэх дасгал, сургуулилт, зөв дадал зуршлыг хэвшүүлэхээр сургалт, үйлчилгээг үзүүлж байна.

ЁС ЗАНШЛЫН ӨРГӨӨ БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

ЕБС-ИЙН БАГШ НАРЫН БҮЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

5,995,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монголын ирээдүй болсон хүүхэд, багачууд маань уламжлалт ёс заншлаасаа холдож, мартаж эхэлж буй нь эмгэнэл болоод байна. Энэ нь бидний амьдралын хэв маяг, хэвшил, мэдээлэл харилцааны хөгжил, ахуй соёлын өөрчлөлттэй холбоотой юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ёс заншлаа дээдэлж, амьдрал ахуйдаа хэвшил болгон мөрдүүлэхэд анхаарч, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан төлөвшүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Монголын үндэсний ахуйг бүрдүүлэх гэр, гэрийн тавилга хэрэгсэл, морь малын тоног хэрэгсэл зэрэг 22 нэр төрлийн сургалтын хэрэглэгдэхүүнийг байршуулна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүүхэд багачууд монгол ёс заншил ахуйгаа дээдлэхэд суралцана. Тухайлбал монгол гэрийн тоног хэрэгсэл, бүтцийг сайн мэдэж өөрсдийн гараар бие даан барьж буулгаж сурна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд ёс заншлын өргөөг тохижуулсан.

ЭРҮҮЛ ХҮҮХЭД ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЭРҮҮЛ НАСЖИЛТ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	5,430,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн хэмжээнд 2018 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан. Одоогоос 2 жилийн өмнө аймгийн хэмжээнд 6 сараас 2 настай хүүхдийг сүү цагаан идээгээр хангах зорилготой “Сүү таргаг” хөтөлбөр хэрэгжиж байсан. Энэ хөтөлбөр нь үр дүнтэй байсан ч хөдөөгийн хүүхэд авахгүй байх тохиолдол их байсан.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Бага насны хүүхдийг хүнс тэжээлийн дутагдалд орохоос сэргийлэх, сүү цагаан идээгээр хангах

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Манлай сумын төвийн 6 сараас 2 нас хүртэл хүүхдүүдийг өдөрт 250 мл үхрийн шинэ сүү таргаар хангана.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сумын төвд амьдардаг, 2 нас хүртэлх хүүхдүүд сүү таргаар хангагдана.
- Хүнс тэжээлийн дутагдлаас сэргийлнэ.
- Хүүхдийн өсөлт хэвийн явагдана.
- Суурь өвчлөлөөс сэргийлэхэд дэм болно.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Манлай суманд сүүний чиглэлийн үхрийн ферм хөгжүүлэхээр ажиллаж буй иргэдийн нийлүүлсэн сүү, таргаар хүүхдүүдийг өдрийн хэрэглээний сүү, таргаар хангаж байгаагаас гадна сумын бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна.

СОЁЛ СПОРТЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“МАНЛАЙН НОГООН АЛТ” ХОРШОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	58,569,167 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Загийн газраас соёл, урлагийн байгууллагад соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг үе шатайгаар хэрэгжүүлэх талаар холбогдох хөтөлбөр, шийдвэрүүд баталсан. Мөн Өмнөговь аймаг 2018 оныг “Бүтээн байгуулалтын жил”, “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Соёл, спорт цогцолбор барилгын гадна орчныг хашаажуулж иргэдийн аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, стресс тайлах, өв тэгш бие бялдартай болгох хөгжүүлэх, алжаал ядаргааг тайлах, урлаг, спорт сонирхогчдын ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аж төрөх хэв маяг, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангах

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын нийт ард иргэд соёл, спортын цогцолборыг бүрэн дүүрэн ашиглаж, соёл урлагийн үйлчилгээний авах ая тухтай орчин бүрдүүлж урлаг, спортын олон талт хэмжээ, сургалт, секц дугуйланг хичээллүүлж цаашид улс, аймаг, бүсийн урлаг, спортын алдартнуудыг төрүүлэх, гоо зүйн мэдрэмжтэй иргэдийг төлөвшүүлэх.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сумын соёлын төвийн ханыг дуу шингээгч хавтангаар өнгөлөх,
- Соёлын төвийн арын эгнээний суудлыг өндөрлөж суурилуулах тавцан хийх,
- Спортын төвийн хананд зураг зуруулах,
- Спортын төв болон соёлын төвийн барилгыг хашаажуулах

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Соёл спортын цогцолборыг бүрэн ашиглаж, иргэдийн аюулгүй орчныг хангаж гадна талбайг хайсжуулах, үзэгчдийг сандалтай болгох, урлаг, соёл, соёл урлагийн үйлчилгээ авах ая тухтай орчин бүрдүүлэх иргэд үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж, эрүүл чийрэг бие бялдартай, ая тухтай нөхцөлд урлаг, спортын олон талт арга хэмжээнд оролцох. Ингэснээр үзэгч, сонирхогчдын тоо нэмэгдэнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Соёл спортын цогцолборыг тойруулан 387м хайс, хаалга хийж суурилуулсан
- Соёлын төвийн хананд 255.2 ам метр шингээгч хавтанг суурилуулсан.
- 93 ам метр талбайд үзэгчдийн шаталсан тавцан хийж 100 ширхэг сандал суурилуулж, 70 ам метр талбайд ханын зураг зуруулсан.

2018 ОНД БАЯН-ОВОО СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

ЭРҮҮЛ МАЛ-ЭРҮҮЛ ХҮНС ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ТҮМЭН СУХАЙТ” ХОРШОО

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

10,836,500 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сүүлийн жилүүдэд мал болон малын хороо, хашаа, бууцыг тогтмол ариутгаж халдваргүйжүүлэхгүй байгаагаас малын халдварт өвчин элбэгшиж малын шимэгч хорхой, халдварт паразитууд ихээр үржих болсон. Иймд мал сүрэгтээ болон малын хороо бууцны ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх шаардлага зайлшгүй тулгараад байна.

Баян-Овоо сум нийт 147,595 толгой мал сүрэгтэй, эдгээр мал сүргийн 133,472 толгой нь тогтмол хариулга маллагаатай, бууц хороондоо амьдардаг бог мал байна. Эдгээр мал сүргийг сумын хэмжээнд 272 хороо бууцанд өвөлжүүлэн хаваржуулж байна. Хороо бууцыг болон хээрээр амьдардаг адуу, тэмээнээс бусад малыг халдваргүйжүүлэлтэнд хамруулснаар мал сүргээс гарах арьс, нэхий, түүхий эд болон ноос ноолуурын чанар нэмэгдэнэ. Баян-Овоо сум нь жилд дунджаар 17,000 орчим арьс нэхий, 94,000 тонн ноос ноолуур бэлтгэн зах зээлд нийлүүлж байна. Малын хороо хашаа, бууцыг ариутгаж халдваргүйжүүлснээр дээрх хэмжээний ноос ноолуур, арьс ширийг чанартай бэлтгэж малчдын орлогын эх үүсвэр баталгаажих боломж бүрдэнэ.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дээрх малчдын 272 хороо, бууцыг ариутгах.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сумын 225 малчин болон мал бүхий өрхийн өвөлжөө, хаваржааны хөрзөнг хуулж, халдваргүйжүүлэх.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сумын нийт малыг ариутгаж, халдварт өвчин болон элдэв шимэгч амьтдаас цэвэрлэснээр малын тарга тэвээрэг нэмэгдэж ашиг шим нь нэмэгдэнэ.
- Хороо бууцны хөрзөнг хуулж ариутган, бууцан дахь шимэгчдийн авгалдай, өндөг зэргийг устгаснаар мал ахин шимэгчээр өвдөхгүй болно.
- Малын ашиг шим сайжирснаар малчдын орлого нэмэгдэнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Баян-Овоо сумын квотын санхүүжилтээр төсөл хөтөлбөр эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүд хуралдан сумын иргэдээс ирсэн хөтөлбөрийн саналуудыг хэлэлцэн “Эрүүл мал-Эрүүл хүнс” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсны дагуу санхүүжилтийг олгон хэрэгжүүлж эхлэв.
- Хөтөлбөрийн гүйцэтгэгч “Түмэн сухайт” хоршоо нь Баян-Овоо суманд мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг “Шурхан залаа” хоршоо, “Өрнөх говь” нөхөрлөлтэй хамтран сумын 3 багийн нутаг дэвсгэр дээрх 225 малчин өрхийн 272 хашаа, хороог ариутгаж шимэгч хорхойн өндөг, авгалдайг устгасан.

НОГООН ТӨГӨЛ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“НОГООН ТӨГӨЛ” НӨХӨРЛӨЛ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

35,400,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сумын тариаланч иргэд тариалсан ногоогоо тээвэрлэн нийлүүлэх, борлуулах үед зориулалтын машингүйгээс хүнсний ногоо амархан муудах, чанарын шаардлага хангахгүй болох зэргээр алдагдал их хүлээдэг нь тариаланч иргэдийн хөдөлмөрийн үнэлэмжийг бууруулж, эдийн засгийн хувьд хохирол учруулж байна. Тиймээс зориулалтын хөргүүртэй чингэлэг бүхий автомшинтай болсноор тариаланч иргэд тариалсан ногоогоо шинээр нь борлуулах боломжтой болох юм. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор сумын тэтгэврийн насны иргэдийг тариалан эрхлэх боломжоор хангах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор зуны тариалалтын хүлэмж нийлүүлэх хэрэгцээ шаардлага байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Тариалан эрхлэх сонирхолтой болон тэтгэврийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
- Сумын иргэдийг сумандаа тариалсан хүнсний ногоогоор хангах.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Зориулалтын хөргүүртэй чингэлэгтэй автомашин худалдан авах
- Зуны хүлэмж авах

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Тариаланчдад зориулалтын тээвэрлэлтийн унаа, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэн шийдсэнээр сумын төвд байнга оршин суудаг тэтгэвэрийн насны, хөдөлмөрийн чадвартай, газар тариалан эрхлэн орлогоо нэмэгдүүлэх сонирхолтой иргэдийг ажлын байраар хангах боломжтой болно.
- Сумын хүнсний ногооны хэрэгцээний 20-30%-ийг хангах боломжтой болно.
- Нарийн ногоогоор сумын иргэдийг хангана.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Бонго 3 загварын хөргүүртэй автомашин авсан.
- Шинээр 2 ажлын байр бий болсон.

ТАВАН ЭРДЭНЭ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

О.ЦЭНДЖАРГАЛ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

28,000,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мал сүргийн тоо жилээс жилд өсөж байгаа энэ үед төрөл бүрийн малын халдварт өвчин их гарах болсон. Иймд малыг эрүүлжүүлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийхийн тулд мал эмнэлэгт хөдөө авч явахад тохиромжтой, ачиж буулгахад хялбар, хөдөлмөр хөнгөвчилсөн, цаг хугацаа хэмнэсэн зөөврийн хашаа чухал хэрэгтэй байгаа билээ. Суурин хашаа руу малаа тууж тарилга туулгаа хийдэг байсан бол ийнхүү зөөврийн хашаатай болсноор малчдын төвлөрөл үүссэн газарт угсарч, бага зардлаар бүтээмж өндөртэй ажиллах боломж бүрдээд байна. Мөн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, мал угаалга, вакцинжуулалт хийхэд тэнд байгаа ажилчид зориулалтын тав тухтай орчинд ажиллах нөхцөл бүрдэнэ.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Мал ариутгалын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөөврийн хашаа, чингэлгээр хангах.
- Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх,

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Баян-Овоо сумын 3 баг тус бүрийг мал ариутгалын зөөврийн хашаагаар хангана.
- Мал ариутгалын үеэр малчны хотонд очиж ариутгалын үйлчилгээ үзүүлж буй ажилчдын байрлах чингэлэг хийнэ,

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Баян-Овоо сумын малчин 328 өрхийн мал бүхий 105 өрхийн нийт 147 мянган мал сүргийг эрүүлжүүлж, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, мал эмнэлгийн үзлэг оношилгоог сайн хийснээр гаднын эх үүсвэрээс орж ирж байгаа мах, сүү, малын түүхий эдийн хэрэглээг 20-30 хувиар багасгах, малын түүхий эдийг үнэд хүргэх, өвчлөл гарсан тохиолдолд малчдад мал эмнэлэг өөрийн унаагаар явуулын үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэнэ. Мөн малчид эрүүл хүнс, эрүүл малын гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэж малчдын орлого нэмэгдэнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

2.5х5м харьцаатай явуулын чингэлэг 1 ш, 1 метр өндөр 50 метр урт 3 ширхэг хашааг хийж мал эмнэлгийн үржлийн тасагт хүлээлгэн өгсөн.

ЦЭВЭР АГААР-ЭРҮҮЛ МЭНД ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Ц.БЯМБАЖАВ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	15,000,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Цэцэрлэг сургуулийн сурагчид болон залуучууд чөлөөт цагаа цэвэр агаарт зөв боловсон өнгөрүүлэх цэвэр тохилог орчин тус суманд шаардлагатай байна. Иймд хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин болох тохилог талбай нэн шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Хүүхэд залуучууд нь эрүүл тохилог орчинд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлснээр эрүүл зөв боловсон хүн болон төлөвших нөхцөл бүрдэнэ

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын биеийн тамирын талбайд 4 сүүдрэвч байрлуулна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Сумын хүүхэд залуучууд цэвэр агаарт тэмцээн уралдаан зохион байгуулах нөхцөл бололцоог бүрдүүлснээр зөв боловсон иргэн болон төлөвшихөд, цаашид эрүүл мэндэд нь тус нэмэр болно.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Баян-Овоо сумын хүүхдийн талбайд 3x5 метрийн хэмжээтэй 4 ширхэг сүүдрэвчийг суурилуулсан.

2018 ОНД ДАЛАНЗАДГАД СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

ЭРҮҮЛ МЭНД ЭРҮҮЛ ОРЧИН



ЗАХИАЛАГЧ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

"АКВАТИК" ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

22,300,000 ТӨГРӨГ

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сурагчдын сурч боловсорч байгаа орчин, нөхцөлтэй эрүүл мэнд нь шууд хамааралтай байдаг ба ЕБС-иудад эрүүл орчин бүрдүүлэх нь хүүхэд багачуудын хувьд хамгийн чухал асуудлуудын нэг болж байна. 2018 оны байдлаар Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6 сургуульд нийт 5900 сурагч суралцаж байгаа бөгөөд улсын төсөвт байгууллагуудад эд хөрөнгө авах зардал тусгагдаагүй байдаг тул сургууль цэцэрлэгүүдийн сурагчдын эрүүл ахуйн орчин нөхцөлийг бүрдүүлж чадахгүйд хүрч байна. Сурагчид сургууль дээрээ хамгийн багадаа 6 цагийг өнгөрөөдөг тул цангаж шингэн дутагдах асуудал үүсэж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6 сургуульд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулж уг сургуулиудад суралцаж буй 5900 сурагч, ажилчдын эрүүл мэндэд хөрөнгө оруулах.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5, 7 дугаар сургуулиудад нийт 18 ширхэг ус цэвэршүүлэгчийн төхөөрөмж нийлүүлж суурилуулна

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулийн 5900 сурагчийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Даланзадгад сумын 6 сургуульд 18 ширхэг ус цэвэршүүлэгчийн төхөөрөмж хүлээлгэн өгсөн

ЭКО АВТОБУСНЫ ТӨЛБӨРИЙН КАРТ ТООЦООНЫ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХ



ЗАХИАЛАГЧ:

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“БИ ТИ ЖИ ТИ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

25,000,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

2018 онд Даланзадгад суманд 8 ширхэг цахилгаан автобус нийлүүлэгдсэн. Уг автобуснуудыг нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж байгаа бөгөөд үйлчилгээгээ төгөлдөржүүлж иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн автобуснуудад картын төлбөрийн тооцооны систем, мэдээллийн дэлгэц суурилуулах шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн картын системийг нэвтрүүлснээр тээврийн үйлчилгээнд явж буй тээврийн хэрэгслүүдийн ажлын даалгавар, түүний гүйцэтгэл, зөрчлийн мэдээ, зорчигч урсгалыг хянах бөгөөд баримтад тулгуурлсан зөв мэдээ тайлантай болж орлого төвлөрөлтийг бий болгох боломжтой болно.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Даланзадгад сумын ОНӨААТҮГ-т 8 ширхэг үндсэн удирдлагын төхөөрөмж, 8 ширхэг карт уншигч төхөөрөмж, 8 ширхэг байршил тогтоогч, дамжуулагч бүхий жолоочийн мэдээллийн дэлгэц, 1500 ширхэг карт нийлүүлж хүлээлгэн өгнө.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Даланзадгад сумын 24,000 оршин суугч, түр оршин суугч, 5045 ахмад настан, 1985 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээг бий болгоно
- Автобусанд зөв боловсон үйлчлүүлэхэд дөхөмтэй болж зорчигчид автобусанд зориулсан бэлэн мөнгө авч явах шаардлагагүй болно
- Стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон автобуснууд нь нийтийн тээврийн үйлчилгээний ажилчид болон зорчигч иргэдийн үйлчлэх, үйлчлүүлэх орчныг сайжруулна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- 8 автобусанд гэрээгээр хүлээсэн бүх төхөөрөмж, карт уншигчийг суурилуулсан
- Зорчигчид автобусаар үйлчлүүлэхдээ карт ашигладаг болсон.
- Нийтийн тээврийн үйлчилгээний явцын тайлан мэдээг тухай бүрт нь авч болдог болсон.

УС-АМЬДРАЛЫН ЭХ БУЛАГ



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ДИВААЖИНГИЙН ЗАМ” ХОРШОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	6,000,000 төгрөг
ХОРШООНЫ ЭХ ҮҮСВЭР:	9,682,500 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Диваажингийн зам хоршоо нь 2014 онд байгуулагдсан. Одоогоор хоршооны эзэмшлийн 12,000 метр квадрат талбай бүхий газар дээр 20 өрх газар тариалан эрхэлж байна. Уг талбайд усны хангамж дутагдалтай байгаагийн улмаас нийт талбайн 25%-ийг л ашиглаж байна. Усны нөөцөө ихэсгэж бүх талбайгаа ашиглах нь хоршооны гишүүдийн амьжиргааг дээшлүүлэх эергээр нөлөөлөх тул худаг гаргах шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

20 өрхийн 67 иргэний амьжиргааг дээшлүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Хоршооны эзэмшлийн газар дээр 40 метрийн гүнтэй гүний худаг гаргаж 1.5 л/с хүчин чадалтай 220V насос суурилуулж худгийн байшин барьж, ус нөөцлөх сав байрлуулан цахилгаан дамжуулах шугам татна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Химийн бодис хэрэглэлгүй уламжлалт аргаар тарьсан хүнсний ногоо тариалалт нэмэгдсэнээр иргэдийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө
- Нэг хүний ажлын байр бий болно
- Талбайн ашиглалт сайжирна

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Гүний өрмийн худаг гаргаж худгийн байшин барьж ус нөөцлөх сав байрлуулсан
- Цахилгаан дамжуулах шугам татсан.

2018 ОНД БАЯНДАЛАЙ СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

“УСАН ХАЛААГУУРЫН ТОГОО, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:	“БИЛГҮҮН ОД КОНСТРАКШН” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	69,359,595 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баяндалай сумын төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн одоо байгаа халаалтын 2 тогоо нь хүчин чадал муутайгаас гадна эвдрэл гэмтэлтэй тул төрийн, төрийн бус байгууллага, иргэдийн орон сууцны барилгуудад дулаан, цэвэр ус дамжуулах хангах хүчин чадал хүрэлцэхгүй байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын төвийн албан байгууллага, айл өрхийг найдвартай дулааны эх үүсвэрээр хангах

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Баяндалай сумын төвийн дулаан хангамжийн системийн эх үүсвэрт 1 ширхэг ШГ маркийн 1400кВ-ын усан халаалтын тогоог үйлдвэрлэн холбогдох тоноглолуудын хамтаар нийлүүлж, суурилуулан туршилт тохируулгыг хийж ашиглалтанд хүлээлгэн өгнө

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Баяндалай сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон 5 төрийн байгууллага, 8 аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид, 23 айл өрхийн иргэд, сургуулийн 306 сурагч, дотуур байрны 86 хүүхэд, цэцэрлэгийн 75 хүүхэд нийт 2500 гаруй хэрэглэгчийг найдвартай дулаанаар хангаж ажиллах, амьдрах таатай орчин нөхцөл бүрдүүлнэ.
- Ард иргэд болон төрийн, төрийн бус байгууллагуудыг дулааны эрчим хүчээр хангах хүчин чадал нэмэгдэж, сумын төвийн шугам сүлжээ, дулааны эх үүсвэрт эвдрэл гэмтэл, хөлдөлт, гацалт гарах эрсдэл буурна
- Дэд бүтцийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг суманд нэвтрүүлэх

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Усан халаагуурын тогоо, тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийг хэрэгжүүлсэн
- Баяндалай сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Баяндалай ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Билгүүн-Од констракшн” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Баяндалай сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Төслийн гүйцэтгэгч “Билгүүн-Од констракшн” ХХК гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Баяндалай сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжинд холбогдсон 5 төрийн байгууллага, 8 аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид, 23 айл өрхийн иргэд, сургуулийн 306 сурагч, дотуур байрны 86 хүүхэд, цэцэрлэгийн 75 хүүхэд нийт 2500 гаруй хэрэглэгчдийг найдвартай дулаанаар хангаж, ажиллах, амьдрах таатай орчин нөхцөл бүрдүүлнэ.

2018 ОНД СЭВРЭЙ СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

“БИД ХӨГЖИНӨ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

О.МӨНХЦЭЦЭГ АХЛАГЧТАЙ ИРГЭДИЙН БҮЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

5,000,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын 20-р цэцэрлэг нь 55 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа 2018-2019 оны хичээлийн жилд өдрийн ангийн 106, тойргийн 180 хүүхдийг хамруулж, 9 багш нийт 14 ажилтны орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Тус цэцэрлэг нь сүүлийн 5 жилд сэтгэхүй хөгжүүлэх тоглоом болон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдаагүйн улмаас хүүхэд хөгжүүлэх орчин нөхцөл муутай байсан.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Хүүхэд хөгжүүлэх тоглоомуудаар хангагдсан цэцэрлэгийн орчин бүрдүүлэх

- 20-р цэцэрлэгийн 4 бүлгийн 106 хүүхэд, тойргийн цэцэрлэгийн насны 180 хүүхдийн оюун санаа, сэтгэл зүйн болон бие бялдрын хөгжлийг сайжруулах, хүүхдэд өөртөө итгэх итгэл, тэсвэр тэвчээр бий болгох, багаар ажиллах, асуудлаа шийдвэрлэх чадваруудыг эзэмшүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сэврэй сумын 20-р цэцэрлэгт 10 нэр төрлийн 118 ширхэг тоглоом нийлүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Хүүхэд хөгжүүлэх тоглоом, хэрэгслээр хангаж, сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулахад хэвийн нөхцөл бүрдүүлсэн
- Хамран сургах тойргийн хүүхдүүд сургуулиас өмнөх боловсрол эзэмших нөхцөл бүрдсэн

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан
- Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч 20-р цэцэрлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч О.Мөнхцэцэг ахлагчтай иргэдийн бүлэг тоглоом нийлүүлэх ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын 20-р цэцэрлэгийн 4 бүлгийн 106 хүүхэд, тойргийн цэцэрлэгийн насны 180 хүүхдийн оюун санаа, сэтгэл зүйн болон бие бялдрын хөгжлийг сайжруулах, хүүхдэд өөртөө итгэх итгэл, тэсвэр тэвчээр бий болгох, багаар ажиллах, асуудлаа шийдвэрлэх чадваруудыг эзэмшүүлэх боломж бүрдэв.

“М.ПУНЦАГИЙН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН БИОЛОГИЙН КАБИНЕТ ТОХИЖУУЛАХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“АРВИН-ЭРДЭНЭ” ИРГЭДИЙН БҮЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

4,982,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын сургуулийн барилга анх баригдсан цагаас хойш буюу 40 гаруй жилийн хугацаанд хими биологийн кабинетын лабораторийн багаж хэрэглэл, бодис урвалж, техник хэрэгсэл, анги танхимын эд хогшилд ямар нэгэн шинэчлэл хийж байгаагүй. Тус сургуулийн хими биологийн кабинетын туршилтын багаж хэрэгсэл муудаж, хоцрогдсон, бодис урвалж чанараа алдсан, хими биологийн үзүүлэн багаж хэрэгсэл байхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан ханын шүүгээ байхгүй зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний дутагдал маш их байна. Мөн сурагчдад байгалийн ухааны төрөл бүрийн сорил туршилт хийх, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөл хангагдахгүй байна

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сургуулийн хими биологийн кабинетыг сургалтын хэрэглэгдэхүүн, багаж, химийн урвалж бодисоор хангаж сурагчдын хичээллэх орчныг стандартын шаардлагад нийцүүлэх

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сэврэй сумын ЕБС-ийн хими, биологийн кабинетад багаж, сургалтын хэрэглэгдэхүүн, химийн урвалж бодис зэрэг 13 нэр төрлийн 75 ширхэг эд зүйлсийг нийлүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сэврэй сумын ЕБС-ийн 7-8-р ангийн 68 сурагчийн байгалийн ухаан, хими, биологийн хичээл явагдах орчин нөхцөл сайжирч тэдэнд юмс үзэгдлийн мөн чанарыг туршилтаар судалж мэдэх чадвар, хүрээлэн буй орчиндоо ээлтэй хандах эерэг хандлагыг төлөвшүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “М.Пунцагийн нэрэмжит ЕБС-ийн биологийн кабинет тохижуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан
- Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Арвин-Эрдэнэ” иргэдийн бүлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Арвин-эрдэнэ” иргэдийн бүлэг тоглоом нийлүүлэх ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын ЕБС-ийн 7-8-р ангийн 68 сурагчийн байгалийн ухаан, хими, биологийн хичээллэх орчин нөхцөл сайжирч тэдэнд юмс үзэгдлийн мөн чанарыг туршилтаар судалж мэдэх чадвар, хүрээлэн буй орчиндоо ээлтэй хандах эерэг хандлагыг төлөвшүүлнэ.

“ХОГГҮЙ ЦЭВЭР СУМ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“АЯГА АРЦ” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

23,700,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Төв суурин газрын хог хаягдлын менежмент муутайгаас хүрээлэн буй орчин, хөрсийг маш ихээр бохирдуулж, цаашлаад хүн амын эрүүл мэнд, хот, тосгоны өнгө үзэмжинд сөргөөр нөлөөлж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Байгууллага, иргэдийг хог хаягдлыг анхан шатанд нь ангилан ялгах нөхцөл боломж, мэдээллээр хангах
- Хог хаягдал зайлуулах үйлчилгээг хариуцдаг байгууллагын машин, техникийг засварлаж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хоггүй цэвэр сум болох

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сэврэй сумын төвийн аж ахуйн нэгж байгууллагуудын гадна болон төв талбайд нийт 30 ширхэг хогийн сав хийж байрлуулах
- Эвдэрсэн хогийн трактор машиныг засаж хэвийн ажиллагаанд оруулах

- Хог хаягдлын ангилан ялгалтын талаар иргэдэд мэдээлэл өгөх
- Хог шатаах зуух барих

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сэврэй сумын төвийн 621 өрх, 2009 иргэд төслийн үр шимийг хүртэнэ
- Сумын төвийн хөрсний бохирдлыг бууруулна
- Байгаль орчноо хамгаална
- Иргэдийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд Хоггүй цэвэр сум төслийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон захиалагчийн шалгаруулсан гүйцэтгэгч “Аяга арц” компанитай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан
- Хэрэгжүүлэгч “Аяга арц” ХХК хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын төвийн 621 өрх, 2009 иргэд төслийн үр шимийг хүртэж, сумын төвийн хөрсний бохирдлыг бууруулж, байгаль орчноо хамгаалахад эерэг үзүүлэлт гарлаа.

“БЯЦХАН ТӨГӨЛ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АЛАГ ЦАВЫН НУРУУ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	1,500,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй суманд мод тарих, ойжуулах ажил маш бага хийгдсэн. Мөн сумын төвийн баруун байрны хороололд хуучин жорлон, муу усны нүх ихтэй хөрсний бохирдолтой бөгөөд ашиглалтгүй олон жил болж байгаа газар байгаа. Иймд энэ газарт ногоон байгууламж байгуулж байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх, сумын өнгө үзэмжийг сайжруулах шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сумын төв дэх хуучин жорлон, муу усны нүх байсан доройтолд орсон газарт ногоон байгууламж бий болгож хөрсний бохирдлыг багасгах, иргэдийн амралт чөлөөт цаг өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн болгох эхлэлийг тавих.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сэврэй сумын төвийн баруун байрны хорооллын 0.14га газрыг тэгшилж хашна
- Талбайг элс, бууцаар бордоно
- Улиас, хайлаас, сухай, агч зэрэг модны нийт 55 ширхэг суулгац суулгана
- Усалгааны 100м шланг талбайд байрлуулна

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сумын төвийн ногоон байгууламж нэмэгдэж сумын өнгө үзэмж сайжирна
- Цөлжилттэй тэмцэх ажилд хувь нэмэр болно
- Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн бий болох эхлэл тавигдана

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Бяцхан төгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон төслийн хэрэгжүүлэгч “Алаг цавын нуруу”ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Гүйцэтгэгч “Алаг цавын нуруу”ХХК хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын сумын төвийн нийтийн эзэмшлийн хөрсний бохирдолд орсон 0,14 га талбайг хашаажуулан мод тарьж байгаль орчин, сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулав.

“ХООЛТ БАГИЙН МУЗЕЙ БАЙГУУЛАХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Г.БАТТӨР АХЛАГЧТАЙ ИРГЭДИЙН БҮЛЭГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	5,833,700 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын Хоолт багийн нутаг дахь Хоёр худагт гэдэг газар нь Хонгорын голын элсний зам дагууд байршилтай бөгөөд одоогоор нутгийн иргэдийн бүлгүүдээс хариуцан замын хажууд задгай модон ширээн дээр гар урлалын бүтээл, малын гаралтай бүтээгдэхүүнээ жуулчдад сурталчлан зарж борлуулдаг бөгөөд урин дулааны улирлуудад тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь цаг агаарын таагүй нөхцөлд иргэдийн бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт найдваргүй, үйлчилгээний соёл муу зэрэг сөрөг дутагдал их байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Нутгийн иргэдийн өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын жуулчдад үндэсний өв соёлыг сурталчлах, түүх соёлоо хойч үеийн залууст танин мэдүүлэх, өвлүүлэх, ард иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сэврэй сумын Хоолт багийн нутагт музейн үзмэр хадгалах зориулалтаар 4м*5м хэмжээтэй төмөр байр барих
- 3м*4м хэмжээтэй 2 ширхэг сүүдрэвч барих
- 1.6м*1.6м хэмжээтэй бетон талбай цутгах
- Нарны ээрчим хүчээр ажиллах гэрэлт цамхаг суурилуулах

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Үндэсний өв соёлыг жуулчдад сурталчлах
- Нутгийн иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх

- Түүх соёлоо хойч үеийн залууст танин мэдүүлэх, өвлүүлэх
- Ард иргэдийн мэдлэг боловсролд нөлөөлөх зэрэг эерэг үр дүн гарах юм

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Хоолт багийн музей байгуулах” төслийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч иргэн Г.Баттөр ахлагчтай иргэдийн бүлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Гүйцэтгэгч Г.Баттөр ахлагчтай иргэдийн бүлэг төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын Хоолт багийн нутагт музейн зориулалтаар ашиглах байртай болж нутгийн иргэдийн өрхийн орлогын эх үүсвэр нэмэгдүүлэх, гадаад, дотоодын жуулчдад үндэсний өв соёлыг сурталчлах, түүх соёлоо хойч үеийн залууст танин мэдүүлэх, өвлүүлэх, ард иргэдийн мэдлэг боловсролд нөлөөлөх зэрэг эерэг үр дүн гарсан юм.

“БҮЙЛСЭН БАГИЙН НУТАГТ МАЛ УГААЛГЫН ВАНН БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	С.БЯМБАДОРЖ АХЛАГЧТАЙ ИРГЭДИЙН БҮЛЭГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	3,500,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын Бүйлсэн багийн нутагт мал угаах, эрүүлжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй байгаа бөгөөд ган зуд тохиолдсон жилүүдэд малын ашиг шим буурч үс ноос гүйцэд ургахгүйд хүрч махл тарга авахгүй улмаас мах, сүүний хангамж муудаж нийгэм, эдийн засгийн хөгжилд муугаар нөлөөлж байна. Иймд тус бүс нутагт мал угаалгын ванн барин нутгийн мал сүргийг халдварт, паразит өвчнүүдээс урьдчилан сэргийлж мал сүргийг эрүүлжүүлэх, иргэдэд эрүүл малаас гарсан бүтээгдэхүүн нийлүүлэх шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сэврэй сумын Бүйлсэн багийн мал сүргийг халдварт, паразит өвчнүүдээс урьдчилан сэргийлж мал сүргийг эрүүлжүүлэх, иргэдэд эрүүл малаас гарсан бүтээгдэхүүн нийлүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сэврэй сумын Бүйлсэн багийн нутагт мал угаалгын ванн барьж ашиглалтанд хүлээлгэн өгнө.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Тус багийн мал сүрэг эрүүлжиж, ган зудыг даван туулах чадвар сайжирна.
- Эрүүл малын бүтээгдэхүүн хэрэглэснээр хүн ардын эрүүл мэндэд тустай.
- Бүйлсэн багийн 40 гаруй айл өрхийн мал сүрэг халдварт болон паразит өвчнөөс хамгаалагдана.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Бүйлсэн багийн нутагт мал угаалгын ванн барих” төслийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч иргэн С.Бямбадорж ахлагчтай иргэдийн бүлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Гүйцэтгэгч С.Бямбадорж ахлагчтай иргэдийн бүлэг төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын Бүйлсэн багийн малчид мал сүргээ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний чанар сайжрах зэрэг эерэг үр дүн гарсан юм.

“ЗҮҮН БАЙРНЫ СПОРТ ТАЛБАЙ ЗАСВАРЛАХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	О.ӨРНӨХ АХЛАГЧТАЙ ИРГЭДИЙН БҮЛЭГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	9,526,800 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын төвийн суурьшил нь баруун байр, төвийн хэсэг, зүүн байр гэсэн 3 хороололд тархан байршсан байдаг. Төслөөр засварлах энэ спорт талбай нь сумын хэмжээний хүүхэд, залуучууд ирж тоглодог ганц талбай юм. Гэтэл бетон талбай хагарч муудсан, сагсны шийд эвдэрсэн, хашаа хамгаалалтгүй байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Хүүхэд залуучуудад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортод дурлах, хичээллэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зэрэг эерэг нөлөөг эрчимжүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сэврэй сумын төвийн Зүүн байрны спорт талбайг засварлаж ашиглалтад хүлээлгэн өгнө.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сумын хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлнэ
- Хүүхэд залуучууд спортод дурлах, хичээллэх нөхцөл бүрдэнэ
- Иргэдэд хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх боломж олгоно.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Зүүн байрны спорт талбай засварлах” төслийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч иргэн О.Өрнөх ахлагчтай иргэдийн бүлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Гүйцэтгэгч О.Өрнөх ахлагчтай иргэдийн бүлэг төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын хүүхэд залуучуудад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортод дурлах, хичээллэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зэрэг эерэг үр дүн гарах юм.

“ТАЙЗНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ХАРАЙХЫН БОР ГҮВЭЭ” ХОРШОО

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

2,240,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын соёлын төвийн тайзны гэрэлтүүлэг стандартын шаардлагад нийцэхгүй байна. Үүнээс шалтгаалан гадаа болон дотор соёл урлагийн үйл ажиллагаа, тоглолт зохион байгуулах нөхцөл боломж хязгаарлагдмал байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сумын соёл урлагийн үйл ажиллагаа явуулах таатай орчин бүрдүүлэн зохион байгуулж байгууллагын өнгө үзэмж, тоног төхөөрөмжийг сайжруулан үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сэврэй сумын соёлын төвд 4 төрлийн 5 ширхэг тайзны гэрэлтүүлэг нийлүүлж, суурилуулна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Сумын болон гаднаас ирсэн уран бүтээлчдийн тоглолтын чанар сайжирч цэнгүүн, соёл урлагийн үйл ажиллагаанд ахиц гарч сумын төвийн нийт иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Тайзны гэрэлтүүлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Харайхын бор гүвээ” хоршоотой санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Хэрэгжүүлэгч “Харайхын бор гүвээ” хоршоо төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын болон гаднаас ирсэн уран бүтээлчдийн тоглолтын чанар сайжирч цэнгүүн, соёл урлагийн үйл ажиллагааг зохион байгуулахад ахиц гарч сумын төвийн нийт иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэв.

“ТҮРГЭН ТУСЛАМЖ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

А.ХЭНЧБИШ ИРГЭДИЙН БҮЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

16,650,000 төгрөг

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сумын эрүүл мэндийн төв нь ихэвчлэн хөдөөгийн дуудлагадаа фургон машинаар үйлчилдэг. Хөдөөгийн дуудлагагүй үед төвдөө фургонгоор түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээ үзүүлдэг боловч шатахуун зарцуулалт их учир төсвийн байгууллагад хүндрэлтэй байдаг. Иймд шатахуун зарцуулалт багатай, сумын төвдөө дуудлагад үйлчлэх жижиг автомашин шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, эмнэлгийн ажилтнуудын ажлын нөхцөл боломжийг сайжруулах

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сэврэй сумын хүн эмнэлэгт Приус 20 маркийн автомашин-1, ханын шкаф-1, хувцас солих хаалт-1, 4 нэр төрлийн 20 ширхэг жижиг хэрэгсэл нийлүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Сэврэй сумын төвийн иргэд түргэн тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй хүртэх, эмнэлгийн үйлчилгээний чанар сайжрах, эмнэлгийн эмч, сувилагчдын ажлын нөхцөл сайжрах зэрэг үр дүн гарна.

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 8 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн хүрээнд “Түргэн тусламж” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн Оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч А.Хэнчбиш ахлагчтай иргэдийн бүлэгтэй санхүүжилтийн гэрээ байгуулав
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан
- Хэрэгжүүлэгч А.Хэнчбиш ахлагчтай иргэдийн бүлэг хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын төвийн иргэд түргэн тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй хүртэх, эмнэлгийн үйлчилгээний чанар сайжрах, эмнэлгийн эмч, сувилагчдын ажиллах нөхцөл сайжрах зэрэг үр дүн гарч байна.

2018 ОНД БУЛГАН СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

ТОГЛООМЫН ТАЛБАЙН ТОХИЖИЛТ



ЗАХИАЛАГЧ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“КОКС ЗАГ” ОНӨААТҮГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

37,669,689 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Булган сумын 5-р цэцэрлэгт 2-5 настай 165 хүүхэд суралцаж, 11 багш ажилчин ажиллаж байна. Тус цэцэрлэгийн гадна талбайн тохижилт муу, стандартын тоглоом байхгүйгээс цэцэрлэгийн орчин нөхцөл шаардлага хангахгүй байна

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Бага насны хүүхэд тоглоход осол аваар гарахааргүй тоглоомтой болж, стандартын шаардлага хангасан гадна талбайн тохижилтын ажил хийнэ

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

№	Нэр төрөл	Тоо ширхэг
1	Ком гулсуур	1
2	Дүүжин даажин	1
3	Гулсуур	1
4	Иж бүрэн шат	1
5	Иж бүрдэл гулсуур	1
6	Резин хавтан шал	102
7	Тоглоомын талбайн барилга угсралын ажил	21,115,825

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Хүүхдийн сурч хөгжих орчин сайжирна
- Багш ажилчдын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бүтээлч сэтгэлгээ идэвхэжнэ
- Хөдөлгөөн, эрүүл мэндийн сургалтын чанарт ахиц гарна
- Багш ажилчид, хүүхдүүд, эцэг эхчүүдийн сэтгэл ханамжид эергээр нөлөөлж тогтвортой сургалтын орчин бий болно

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулан хэрэгжүүлж эхэлсэн.

ЭРЭГТЭЙ ТЕХНОЛОГИЙН КАБИНЕТ



ЗАХИАЛАГЧ:

БУЛГАН СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“БАЯНЗАГ ДИНОЗАВР” ХХК

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

27,649,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 5-9 дүгээр ангийн 60 гаруй эрэгтэй сурагчид 7 хоногт 2 цагаар технологийн хичээлд хамрагддаг. Гэтэл технологийн хичээлээр сурагчдад мэдлэг чадвар эзэмшүүлэх, хичээл сургалт явуулах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байхгүйгээс сурагчдад онолын мэдлэг эзэмшүүлэх, гарын доорх материалаар ойр зуурын зүйлс хийлгүүлэхээс хэтрэхгүй байна. Иймээс дизайн технологийн хичээлээр сурагчдад мэдлэг чадвар олгох, тэднийг ур дүй, хөдөлмөрт сургах нэгдсэн хөтөлбөрийн дагуу сургалт явуулах нөхцөл боломж байхгүй байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сумын ЕБС-д дизайн технологийн кабинет байгуулах

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын ЕБС-д дизайн технологийн хичээл заах, зохион байгуулах, сургалт, дадлага олгох зориулалтын танхим байгуулж багаж, тоног төхөөрөмжөөр хангана.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- 201 сурагч, 15 багш, 12 ажилтны сурч ажиллах орчин нөхцөлийг сайжруулна
- Зориулалтын дизайн технологийн танхим тохижуулж багаж тоног төхөөрөмж нийлүүлнэ
- Хичээлээс гадуур дугуйлан зохион байгуулах сурагчдын сонирхлын дагуу тогтмол үр дүнтэй хичээллэх

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулан хэрэгжүүлж эхэлсэн.

2018 ОНД НОМГОН СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

ГОМБОСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

НОМГОН СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“НОМГОН ХӨГЖЛИЙН ГАРЦ” ТББ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

56,000,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Номгон сумын хүүхэд багачуудад дулааны улиралд эрүүл орчин, цэцэрлэгт хүрээлэн, ойн зурвас бүхий чийглэг уур амьсгалтай газар тоглох наадах талбай хомс байдаг нь хүүхэд залуучуудыг хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг хязгаарладаг.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Орон нутгийн иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, сумын хөгжлийг залууст хүртээмжтэй болгохиргэдийн оролцоог нэмэгдүүлэх

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын төвд ногоон зурвас бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сум орон нутгийн өнгө үзэмж нэмэгдэнэ.
- Залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин бүрдэнэ.
- Иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Сумын ногоон байгууламж нэмэгдэнэ.
- Хүрээлэнд хувиараа бизнес эрхлэх боломж бүрдэнэ.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Номгон сумын төвд 100х50 метрийн харьцаатай хүүхэд, залуучууд болон сумын иргэд зугаалж, тоглон чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан.

ЭРДЭНЭБУЛАГИЙН НОГООН ТАЛБАЙГ ХАШААЖУУЛАХ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	НОМГОН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"ХӨРХИЙН НАРАН" ХОРШОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	13,500,000 төгрөг

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хөрхийн наран хоршооны тариаланчид нь Номгон сумын хүнсний ногооны хэрэгцээг хангадаг ногоочдын бүлгэм юм. Уг бүлгэм нь нийт 15 га газарт тариалан эрхэлдэг бөгөөд тариалангийн талбай нь тусгайлсан хашаагүй учир мал сүргээс гадна туулай зэрэг зэрлэг амьтад тариалсан хүнсний ногоог идэх, ухаж хаях зэргээр хүнсний ногооны тариаланд ихээхэн хохирол учруулдаг.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Эрдэнэбулагийн ногооны талбайг хашаажуулах.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын ногооны талбайд тариалсан хүнсний ногоог мал болон зэрлэг амьтдаас хамгаалсан зориулалтын тортой хашаагаар хашиж хамгаална.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Төсөл хэрэгжсэнээр 18 өрхийн 25 тариалан эрхлэгч 15га газарт тариалсан төрөл бүрийн хүнсний ногоо, ургацаа бүрэн хураан авч амьжиргааны түвшин дээшилнэ.
- Хашаажуулснаар тариалалт нэмэгдэж олон нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаснаар хүн амын хүнсний хэрэгцээг хангана.
